

**Цуврал № 2: Цөмийн хаягдлын бизнест хэн хэн оролцож байна вэ
буюу**

“Монголын Цөмийн Санаачлага” гэгч төсөл Монголд ашигтай юу?

Өмнөх үг

Монголын болон гадаадын хэвлэлд гарсан баримт мэдээнд тулгуурлан Монгол улсад уран олборлох, АЦС барих нэрийдлээр олон улсын цөмийн хаягдлыг булшлах төлөвлөгөө хэрхэн хэрэгжиж буйг баримт нотолгоогоор үзүүлэхийг зорьж энэ нийтлэлийг бэлтгэлээ.

Нийтлэлд ашигласан баримт мэдээллийг хэн нэгнээс авах шаардлага надад байхгүй. Гадна дотны эх сурвалжуудыг ширхэг бүрчлэн судалж цуглуулснаа эх сурвалжтай нь тавьсаныг хавсралтаас хараарай. Хорон үгээр над руу дайрагчдад хандаж дэлгэж тавьсан баримтыг бодитой үндэслэл, нотолгоогоор няцаахыг уриалья.

Өнөөдөр Монгол залуус эрх баригчдаар “тархиа угаалгаж”, тэдний мулгуу үгээр “будаа идэж”, элэг бариулж хууртагдаж суухааргүй, мэдээллийг өөрсдөө олж шинжлэн дүгнээд, худал үнэнийг ялгах, ирээдүйгээ харж төсөөлөх чадвартай болсон шүү!

Уншигч таны зүрхэнд эх орноо гэсэн өчүүхэн ч болтугай сэтгэл байдаг бол энд тавьсан мэдээллийг өргөн олны хүртээл болгоход туслаарай. Хүнийрхүү хандаж хүлээж суувал хожим бидэнд харамсаад баршгүй их гарз хохирол учрах болно гэдгийг бодоорой.

Би маргаашийн Монголын төлөө өөрийн цаг зав, эрч хүч, зүрх сэтгэлээ зориулж байна. Харин та?

Хүндэтгэсэн,

Амарлин

<http://golomt.org>

Оршил

Цувралын 1-р хэсэгт 2007 оны 11 сараас 2009 оны 10 сарын сүүл хүртэлх хугацаанд буюу С. Баярын засгийн газрын үед Монгол улсад цөмийн эрчим хүчний өнөөгийн тогтолцоо хэрхэн үүсч хөгжсөн талаар дэлгэрэнгүй өгүүлсэн (1). С. Баяр Олон Улсын Атомын Энергийн Агентлагийнхантай удаа дараа уулзаж, уран олборлох, цөмийн салбарт хамтран ажиллах олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг гардан хийжээ (Энэтхэгт цөмийн түлш нийлүүлэх гэрээнээс бусдыг). Чухамдаа Японд цөмийн хэлэлцээр хийхээр явсан С. Баярын шахалтаар л Цөмийн Энергийн тухай хуулийн эхний ба эцсийн хэлэлцүүлгийг УИХ ганцхан өдөрт багтаан “бөөндөж” байсан.

С. Баярын шадар туслах В. Долгорын удирдсан ажлын хэсгийнхэн хэлэлцэж буй баримт бичгүүдэд дутуу дулимаг тайлбар, хуудуутай засвар хийж байсны улмаас Монгол улсад гадны цөмийн хаягдлыг хадгалах, булшлах боломж олгосон төрөөс баримтлах цөмийн салбарын бодлого, хууль батлагдаж гарчээ. Түүнчлэн, уран олборлох лиценз олгох, лицензийг цуцлах, цөмийн хаягдлыг булшлах зэрэг үйл ажиллагааны хэрэгжилт, хяналтын хэмжээлшгүй эрхийг ерөнхий сайдын байгуулсан, түүний гар дорхи агентлаг болох Цөмийн Энергийн газар, түүний харъяа “МонАтом” компанид Цөмийн Энергийн “цоорхой” хуулиар атгуулсан тухай баримт нотолгоог өмнөх нийтлэлээр дэлгэсэн билээ (1).

2009 оны 10 сарын 26-нд С. Баяр “эрүүл мэндийн” гэдэг шалтгаанаар ерөнхий сайдын суудлыг чөлөөлж, С. Батболдыг залгамжлагчаараа тодруулжээ. Тэр цагаас хойш Монголын цөмийн салбарт үйл явдал хэрхэн өрнөсөн бэ?

С. Батболдын засгийн газар буюу 2009 оны 10 сарын 29-өөс өнөөдрийг хүртэл



С. Баярын үед Монголд цөмийн эрчим хүчний өнөөгийн тогтолцооны үндэс суурь дөнгөж тавигдаж, хэрэгжүүлэгч механизм, багууд үүсэн байгуулагдаж байсан тул дийлэнхдээ С. Баярын ганцаарчилсан тоглолт давамгайлж байжээ. Тухайлбал, ОХУ, Франц, Япон явж хэлэлцээр хийх, Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн ерөнхий захиралтай уулзах зэргийг С. Баяр бие даан шийдэж байв. Цөмийн Энергийн газрын дарга С. Энхбатын хувьд даргынхаа байгуулсан гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурж явжээ.

Харин С. Батболдын үед ерөнхийлөгч ба ерөнхий сайдын хүч хавсарсан бүлэглэл үүсч, түүнд УИХ-ын дарга, сайд, УИХ-ын гишүүд, түүнчлэн нэр бүхий улс төр, нийгмийн зүтгэлтнүүд нэгдэж, цогц бодлого явуулах болов. Зааж зөвлөх гадна дотны хамсаатан сүлбээтэн ч нэмэгдэж. Түүнчлэн зөвхөн уран гэлтгүй “газрын ховор металл” гэгч уранаас хэд дахин үнэтэй ашигт малтмалын асуудал гарч ирсэн талаар цухас өгүүлэх болно.



Ингээд гадаад дотоодын эх сурвалжуудад



тулгуурласан дэлгэрэнгүй тайлбар хүргэе. Дашрамд нэг зүйлийг анхааруулахад Монголын хэвлэлд гарсан дийлэнх мэдээнд “уран олборлох”, “цөмийн хаягдал булшлах байгууламж барих”, “цөмийн түлш бэлтгэн нийлүүлэх”, гэдэг үг хэллэгийг цээрлэж, “уул уурхайн салбарт хамтрах”, “цөмийн түлшний иж бүрэн үйлчилгээ”, “дэд бүтцийг хөгжүүлэх”, “цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах”, “эрчим хүч, уул уурхайн салбарын аюулгүй байдлыг хангах”, “уул уурхай, эрчим хүчний салбарыг хөгжүүлэх” зэрэг гэмгүй үгээр халхавчилдгийг болгоож уншина уу.

- **ОХУ, Энэтхэг, Франц, Япон, АНУ-тай хэлэлцээр хийсэн нь**

2009 оны хавар ерөнхийлөгчийн сонгуульд ялсан Ц. Элбэгдорж 8 сарын 25-нд ОХУ-ын ерөнхийлөгч Д. Медведевийг Монголд айлчлахад стратеги түншлэл хөгжүүлэх тухай тунхагт гарын үсэг зурснаар цөмийн асуудалд оролцох болов. Тус айлчлалын үеэр ОХУ-тай хамтран “Дорнод уран” ХХК байгуулахаар тохиролцож, Монголын талаас Цөмийн Энергийн газрын дарга С. Энхбат, ОХУ-ын талаас “Росатом” цөмийн эрчим хүчний улсын корпорацийн ерөнхий захирал С. Кириенко нар гарын үсэг зуржээ (2,3).

2009 оны 9 сарын 13-16-нд ерөнхийлөгч Ц. Элбэгдорж анхныхаа айлчлалыг Энэтхэг улсаас эхэлсэн байна. Тэрбээр ерөнхий сайд Манмохан Сингхтэй цацраг



идэвхт бодис, цөмийн эрчим хүчийг энхийн зорилгод ашиглах асуудлаар хамтран ажиллахаар тохиролцож, улмаар цөмийн түлш ханган нийлүүлэх пакт гэрээг бусад 4 гэрээний хамтаар байгуулав. Үүнийхээ хариуд Энэтхэг улсаас 25 сая ам. долларыг хөнгөлөлттэй зээл авахаар тохирчээ. Блумберг болон Энэтхэгийн өдөр тутмын сонинуудаар “Монголчууд цөмийн түлш нийлүүлэхээр боллоо” гэж шуугиж байхад Ц. Элбэгдоржийн албан ёсны

сайт <http://president.mn> ч, Монголын бусад мэдээллийн сайтууд ч цөмийн түлшний гэрээний талаар ганц үг дурьдаагүй нь нэгийг бодогдуулна. Ерөнхийлөгчийн сайт гэхэд бусад 4 гэрээний ач холбогдлын талаар дэлгэрэнгүй бичсэн мөртлөө цөмийн түлш нийлүүлэх гэрээний хувьд “цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах салбарт хамтран ажиллах санамж бичиг байгуулсан” гэдгээс илүү мэдээлэл өгөлгүй нууцалжээ (4,5,6,7,8).

Үйл явдал цааш нь хэрхэн өрнөсөн талаар сонирхье. 2010 оны 1 сарын 11-нд БСШУЯ-ны сайд Ё. Отгонбаяр Энэтхэгийн “DNA India” сонинд ярилцлага өгөхдөө “Монголын цөмийн энергийн мэргэжилтнүүд Энэтхэгт очиж хоёр талын байгуулсан цөмийн гэрээг хэрэгжүүлэх арга боломжийг судалсан. Одоо бид Энэтхэгийн цөмийн мэргэжилтнүүдийг хүлээж авна” гэжээ (9). ГХ-ны яамны тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд А.Ундраа ч 2011 оны 5 сарын 19-ны “Дуусдаггүй Яриа-Цөмийн хаягдал” телевизийн нэвтрүүлэгт Энэтхэгийн АЦС-уудыг үзэж, цөмийн салбарынх нь хөгжлийг биширснээ хальт дурьдснаас үзвэл (82) хоёр улсын хооронд эрчимтэй солилцоо далдуур явагдаж буй нь үнэн ажээ.

“The Hindu” сонинд Боловсролын сайд Ё. Отгонбаяр Энэтхэгийн Гадаад Хэргийн сайд Принийт Кауртай уулзаж, Ц. Элбэгдорж ерөнхийлөгчийн айлчлалын

үеэр хийсэн яриа тохиролцоог шинэчлэн бататгахын сацуу хоёр орныг иж бүрэн хамтын ажиллагааны түвшинд ажиллах санал тавьсан тухай бичсэн байна. Түүнчлэн Ё. Отгонбаяр Энэтхэг-Монголын хамтарсан компани байгуулах, хөрөнгө оруулах, уран олборлолтод оролцохыг уриалжээ (10). Энэтхэгийн Jindal Steel компани Монголын говьд ураны хайгуул хийж байгаа гэсэн мэдээнээс (11) харахад Энэтхэгчүүд түүний саналыг хүлээн авсан бололтой.



2009 оны 10-р сарын эхээр Францын “Арева” группын захирал Анн Лувержон Монголд айлчлахдаа ерөнхийлөгч Ц. Элбэгдоржтой тусгайлан уулзав. Ерөнхийлөгч цөмийн салбарын “чухал ач холбогдлыг” тэмдэглээд, тус салбарт Франц улстай үргэлжлүүлэн ажиллах хүсэлтэй гэжээ (12). Хатагтай Лувержон С. Баяр, С. Батболд нартай ч уулзаж ярилцсан байна. Улмаар 10 сарын 5-нд Цөмийн Энергийн газрын дарга С. Энхбат “Арева”- тай уран олборлох чиглэлд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав (13).

2009 оны 12 сард ерөнхий сайд С.Батболд “Цөмийн технологи--Монгол Улсын хөгжил” зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, цөмийн энергийн салбарыг хөгжүүлэхэд онцгой анхаарна гэж зарлажээ. Мөн цөмийн эрчим хүчийг **“байгаль орчинд халгүй, хөнөөл багатай, аюулгүй технологи”** гэж тайлбарлав (14). С. Батболд ураны чулуулгийн хүдрийн ордыг далд аргаар ашиглахдаа өртөг зардал бага, хялбар бөгөөд дэвшилттэй технологи болох гүний уусгалтын технологийг нэвтрүүлнэ, эхний ээлжинд Хараат, Хайрхан, Дулаан Уулын ордуудыг ашиглана гэсэн байна. Харин эдгээр ажлуудыг гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар төрийн өмчийн “МонАтом” компанийн удирдлагууд идэвхи санаачлагатай ажиллах хэрэгтэй гэж ярьжээ (14).



2010 оны 3 сард С. Батболд Австри улсад айлчилж Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн (ОУАЭА) удирдлагад бараалхжээ (15). Сонирхолтой нь энэ үед С. Батболд засгийн эрхэнд гараад 5 сар болж байсан байна. С. Баяр ч мөн ижил ерөнхий сайд болсноосоо хойш 5 сарын дараа Вена орж, ОУАЭА-ийн ерөнхий захирал Мохамед Эль Барадей гэгчтэй уулзаж байжээ (49).



2010 оны 4 сарын эхээр С. Батболд Хайнанд болсон Боаогийн форумд оролцохдоо Хятадын ерөнхий сайдтай уулзаж, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар хэлэлцээр хийв (16). 2010 оны 4 сарын 28-аас --5 сарын 3-нд Ц. Элбэгдорж Хятадад айлчилж, Ху Жинтаотой уулзав. Хятадын ерөнхийлөгч 2 орны хамтын ажиллагааг олон салбарт

бэхжүүлэх, үүнд уул уурхайн салбарт хамтрах нь чухлыг тэмдэглэсэн байна (17). Үүнээс хойш сар ч бололгүй 5 сарын 31-ээс ---6 сарын 2-нд Хятадын ерөнхий сайд Вэнь Зябао Монгол улсад 2 хоногоор айлчлахдаа уран, цөмийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах талаар Монгол улсын ерөнхий сайд С. Батболд, ерөнхийлөгч Ц. Элбэгдорж нартай ярилцжээ (18).

Түүний айлчлалын үеэр Хятадын төрийн мэдлийн Үндэсний цөмийн корпораци -- China National Nuclear Corporation (CNNC) -- Цөмийн Энергийн газартай цацраг бодис, цөмийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, С. Энхбат гарын үсэг зуржээ (19,20).

Хятадын ерөнхий сайд уулзалтанд сэтгэл ханамжтай байсан бололтой Монголын уул уурхай дэд бүтцийг хөгжүүлэхэд 800 сая ам. долларын зээл олгохоор амлажээ (21).



2010 оны 6 сард ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Туркийн Станбул хотод болсон Азид хамтын ажиллагааны итгэлцлийг бэхжүүлэх зөвлөлийн дээд хэмжээний уулзалтанд оролцохдоо ГХ-ны сайд Г.Занданшатарыг дагуулж явжээ. Тус хуралдааны үеэр Г. Занданшатар далайд гарцгүй орнуудын транзит тээврийн асуудлаар уран экспортлох тал дээр туршлагатай Казакстан улсын ГХ-ийн сайд К.Б.Саудабаевтай уулзаж, Казакстаны уран


экспортлодог туршлагаас судалжээ. Улмаар энэ чиглэлээр хоёр талын Засгийн газар хоорондын комиссыг хуралдуулж, уул уурхай, эдийн засаг, транзит тээвэр, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр санал солилцохоор тохирсон байна (22).

Харин энэ завсар Япончууд цөмийн салбар дахь хамтын ажиллагаагаа улам эрчимжүүлэхээр шавдуулах болов. Г.Занданшатар Туркээс ирээд 2010 оны 7 сарын 15-23-нд Ханойд болсон Зүүн өмнөд Азийн орнуудын сайд нарын уулзалтанд очиход Японы ГХ-ийн сайд Окада уул уурхайн салбар, нэн ялангуяа ураны салбарт хамтран ажиллах хүсэлтэйгээ Г. Занданшатарт сануулжээ (23).

Дараахан нь буюу 7 сарын 29-өөс -8 сарын 3-ны хооронд ЭБЭХ-ний сайд Д. Зоригтийг Япон улсад айлчлахад Окада уулзаж ураны салбарт хамтрах асуудлаар дахин ярилцав (23, 24, 25). Айлчлалын үеэр Д. Зоригт Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны банк гэгчтэй харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, алт, зэс, ураны нөөцтэй Монгол улсад бизнес үйл ажиллагаа явуулах Японы компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар тохирчээ (26). Түүнчлэн ЭБЭХ-ний сайд Японы Аж үйлдвэрийн шинжлэх ухаан, хөгжингүй технологийн үндэсний институтынхэнтэй харилцан ойлголцлын цогц хэлбэрийн санамж бичгийг үзэглэсэн байна. Тус гэрээнд Монгол улсын геологийн хайгуул, ашигт малтмалын, нэн ялангуяа газрын ховор металлын судалгааг хийлгэхээр тусгажээ (27).



Япончууд ураны асуудлаар хамтрахаар яаравчилж байсны өөр нэг нотолгоо нь 2010 оны 8 сарын 30-нд ГХ-ийн сайд Кацуя Окада сүүлийн зургаан жилд анх удаагаа Монголд айлчилж, Ц. Элбэгдорж, Г. Занданшатар нартай уулзсан явдал юм (23). Тэрбээр уул уурхай, нэн ялангуяа ураны салбарт хамтран ажиллах талаар нарийвчлан ярилцжээ. Монголчууд хариуд нь Японы компаниудад бизнесийн таатай орчин бүрдүүлнэ гэсэн амлалт өгсөн байна (23).



2010 оны 9 сард АНУ-ын Эрчим хүчний дэд сайд Понеман Монголд ирэв. Тэрбээр 9 сарын 22-нд ГХ-ны сайд Г.Занданшатартай “Цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах

салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зуржээ (28, 29). Харин гадаадын хэвлэлд Монголд цөмийн хаягдал булшлах тухай асуудалд Даниел Понеман чухал үүрэг гүйцэтгэсэн гээд Японы Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам болон Монголын Гадаад Харилцааны яамныхан оролцсон гэж бичжээ (30). АНУ-ын Төрийн Департаментийн албаны дарга Ричард Стратфорд ч Монгол улстай цөмийн хаягдлын талаар 2010 оны намраас хэлэлцэж эхэлсэн тухай энэ оны 3 сард Вашингтонд болсон Олон улсын Цөмийн Бодлогын хурал дээр дурдсан билээ (71).


Даниел Понеманыг ирэхэд ерөнхий сайд эзгүй байсан тул тэрбээр шадар сайд М.Энхболдтой уулзаж (31), ШУТИС дээр лекц уншжээ. Түүний лекцийг ГХ-ийн яамны тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд А. Ундраагийн удирддаг “МонАме” сургалтын төвөөс АНУ-ын ЭСЯ-тай хамтран санхүүжүүлсэн байна. Тус төвийн ТУЗ-д эрхэм гишүүн С. Оюун, ерөнхий захирлаар А. Ундраагийн нөхөр Д. Дашдорж ажилладаг ажээ (32).



2010 оны 10 сард Францын Гадаад Худалдааны сайд хатагтай Анн-Мари Идрак Монголд айлчилж, Ц. Элбэгдорж болон УИХ-ын дарга Д. Дэмбэрэлтэй уулзав. Тэрбээр цөмийн энергийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт ГХ-ны сайд Г. Занданшатартай гарын үсэг зуржээ (33).

- **Канад, Япон, ОХУ, Арабын Нэгдсэн Эмират, Хятад, Солонгостой хэлэлцээр хийсэн нь**

2010 оны 9 сарын 28-аас--10 сарын 1-ний өдрүүдэд ерөнхий сайд С. Батболд Канад улсад айлчилж 3 төрлийн харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав (34). Түүнийг дагалдан явсан “МонАтом” компанийн захирал Р.Бадамдамдин ураны хайгуул, олборлолт хийдэг “Денисон Майнз” компанитай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна (35).



Ерөнхий сайд Канадаас шууд Япон улс руу жолоо залж, 2010 оны 10 сарын 3-нд асашёорюу Дагвадоржийн зодог тайлах ёслолд оролцжээ (36). Харин далимд нь Японы ерөнхий сайд Наото Кан, бусад улс төрчид болон Тошиба, Мицубиши, Марубени, Мицуи, Сумимото, Иточу корпорацийн төлөөлөгчидтэй уулзаж, хоёр улсын стратегийн түншлэлийг өргөжүүлэх, чухамдаа бол уран болон газрын

ховор металлын салбарт хамтрахаар тохиролцжээ (37, 38, 39, 40).

Энэ уулзалт С. Батболд, Наото Кан хоёрын хувьд сүүлийн арваад хоногийн доторхи хоёр дахь уулзалт байсан нь анхаарал татаж байна. Хоёр ерөнхий сайд хэдхэн хоногийн өмнө буюу 9 сарын 24-нд АНУ-ын Нью Йорк хотноо уулзахдаа ашигт малтмал, дэд бүтэц, газрын ховор металл ашиглах талаар ярилцаж байжээ (39, 40).

Чухам 10 сарын 2-ны уулзалтын үеэр С. Батболд Монголын эрдэс баялаг, Японы техник технологийг хослуулан нэмүү өртөг шингээх боловсруулах үйлдвэр байгуулах сонирхолтой байгаагаа онцлон дурьджээ. Түүнчлэн газрын баялгийг хамтран хайх, **төмөр замыг уул уурхайтай холбох**, Таван Толгой, газрын ховор элемент, **транзит тээвэр** зэрэг төслүүд дээр харилцан ашигтай хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн байна (40).

Ерөнхий сайдын “шилийг даран” ерөнхийлөгч Ц. Элбэгдорж Японд дээд хэмжээний уулзалт хийхээр 11 сарын 14-19-нд айлчлахдаа ерөнхий сайд Наото Кантай стратеги түншлэлийн гэрээнд гарын үсэг зурав. Тус баримт бичгийн 3-рт **“Газрын ховор металл, уран, бусад ховор ашигт малтмал олборлож, боловсруулах асуудлаар хамтрах”** тухай заажээ. Ерөнхийлөгчийг Лу. Болд, Г. Занданшатар нар дагалдсан ба <http://president.mn> энэ талаар аанай л бичсэнгүй орхигдуулжээ (41, 42, 43).





Ерөнхийлөгчийн айлчлалаас долоо хоногийн дараа 11 сарын 26-нд цөмийн реактор үйлдвэрлэгч Японы Тошиба корпорациас Монголын “MN FCC” компанитай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, цаашид Монголын ашигт малтмалыг, үүнд уран, газрын ховор металл зэргийг боловсруулах, хөдөөгийн дэд бүтцийг сайжруулах тал дээр хамтран ажиллахаар болжээ (44). 2010 оны 9 сард байгуулагдсан төрийн ба хувийн өмчийг хослуулсан хэмээх “MN FCC” ХХК захирал нь Дүгэрсүрэнгийн Дашдорж буюу ГХ-ийн яамны тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайдын албыг хашдаг А. Ундраагийн нөхөр юм байна (44). Дашрамд

дурьдахад, Монголын уран, газрын ховор металл зэрэг баялгийг арлын Япон руу зөөх Хятадаар дамжсан төмөр зам тавих төсөл хэрэгжиж байгаа талаар Цуврал-3-т тодорхой бичих болно. Эргүүлээд харин Монгол руу юу зөөх бол?

TOSHIBA
 Leading Innovation >>>

About Toshiba

[Home](#) > [News Releases](#) >

Search in releases

News Releases
 > Search by Month
 > Search by Subject
 > Search by Company

Main Menu
 > Corporate Information
 > News Releases
 > Investor Relations
 > Social and Environmental Activities
 > Technologies
 > Employment Opportunities
 > International Procurement
 Country or Area Sites
 Country or Area

Toshiba Signs Memorandum of Understanding on Cooperation in Development of Mineral Resources and Social Infrastructure with Mongolia's MNFCC

26 Nov, 2010

TOKYO — Toshiba Corporation (TOKYO: 6502) and Mongolia's MNFCC LLC signed a Memorandum of Understanding (MOU) under which they will initiate discussions on possible cooperation in the development of Mongolia's mineral resources, including uranium, rare earth and rare metals products, and enhancement of the country's social infrastructure.

Mr. Naoto Kan, the Prime Minister of Japan, met the Mongolian President, Mr. Tsakhiagiin Elbegdorj, on November 19, 2010, and the two agreed to build a strategic partnership and to secure mutually beneficial cooperation in developing mineral resources in Mongolia. Further moves to promote an economic relationship between Japan and Mongolia are expected.

On the basis of the MOU, Toshiba will seek to secure a mutually beneficial cooperative relationship with MNFCC, which is charged with providing strategic advice and policy implementation in the areas of mineral resources, energy, and social infrastructure under Mongolia's public-private-partnership program. Toshiba will conduct feasibility studies on key social infrastructure essential for securing Mongolia's continued economic growth, including thermal, nuclear and solar photovoltaic power systems and transmission and distribution networks and will seek to promote mutual development of mineral resources in an effort to secure stable supply.

About MNFCC

Company Name:	<u>MNFCC LLC</u>	← Компаний нэр
Founded:	<u>September 2010</u>	← Байгуулагдсан огноо
Representative:	<u>Dugersuren Dashdorj</u>	← Төлөөлөгчийн овог, нэр
Lines of Business:	Implementation of Mongolian public-private-partnership for development of mineral resources, energy and social infrastructure	

Эх сурвалж: http://www.toshiba.co.jp/about/press/2010_11/pr2601.htm



2010 оны 11 сард “МонАтом”-ын Р. Бадамдамдин, УИХ-ын гишүүн П. Алтангэрэл, Ц. Батбаяр нар АНУ-ын Вашингтон хотыг зорьжээ (45). Тэд АНУ-ын Эрчим хүчний яамны дэд сайд Даниел Понеман, Цөмийн зохицуулалтын комиссын дарга Григорий Жакско, мөн комиссын Олон улсын хөтөлбөрийн асуудал хариуцсан захирал Маргарет Доане, Америкийн үндэсний уул уурхайн холбооны төлөөллүүдтэй уулзаж, хоёр талын хамтын ажиллагааны талаар санал солилцсон байна. Улмаар, уран олборлох, ашиглах, баяжуулах, түлш үйлдвэрлэх үйл ажиллагаа түүний хууль эрх зүйн зохицуулалт, дүрэм, журам болон тэдгээрийн хэрэгжилт, хяналт шалгалтын чиглэлээр туршлага судалж, АНУ-ын Цөмийн зохицуулалтын комиссын цөмийн салбарын хуулийг дагаж мөрдөхтэй холбогдсон дүрэм, журмыг боловсруулах үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцаж, далимаар нь Канад ч ороод амжжээ (45).

АНУ-аас ирснийхээ дараахан өгсөн ярилцлагадаа П. Алтангэрэл: “Бид АНУ-ын мэргэжилтнүүдтэй уулзахдаа **"Шар нунтагаа олборлоно ч, хөрвүүлнэ ч баяжуулна ч, тэгээд цөмийн түлш болгоно"** гэж ярихаар **шоолоод байсан**. Тэд хөрвүүлж, баяжуулдаг үйлдвэр чинь дэлхийн хэмжээнд 3-4-хэн байдаг гэж байсан. Асар том "үйлдвэрлэл явуулдаг Казахстан ингэж ярьдаггүй гэж байсан. Хөрвүүлээд баяжуулдаг газар нь аваачаад, **өөрийн нутаг дээрээ цөмийн банк байгуулах нь арай итгэл үнэмшилтэй сонсогдож байна** гэсэн. Туршлага судлахаар явсных нэг мэдсэн чухал зүйл маань энэ. Ямар ч байсан уранаа олборлох ёстой юм байна. Олборлосон шар нунтагаа хөрвүүлдэг, баяжуулдаг үйлдвэрт нь аваачиж **цөмийн түлш болгон атомын станц байгуулж, түрээслүүлэх маягаар ашиглах хэрэгтэй юм байна**. Уранаа ингэж эдийн засгийн эргэлтэд оруулах нь зөв юм байна гэж зөвлөж байна, тэд” гэж ярьжээ (46).



Эрхэм гишүүн **"цөмийн түлшний банк"** буюу уран олборлож, өөр улсад цөмийн түлш болгон үйлдвэрлүүлж, бусдад борлуулаад, эцэст нь ашигласан түлшнийх нь хаягдлыг эргүүлж авч нутагтаа булшлахсаналыг мэргэн шийдэл гэж тайлбарлаад

өнгөрчээ.


Харин Олон Улсын Атомын Энергийн Агентлагаас гаргасан баримт бичигт **“цөмийн түлш зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэгч улс орон нь өөрийн нутаг дээр олон улсын цөмийн хаягдлын байгууламжтай байх** буюу гуравдагч орон дахь тийм байгууламжийг ашиглах ёстой” гэж бичсэн байдаг ажээ (50, хуудас 15). Харин өнөөг хүртэл олон улсын цөмийн хаягдлын байгууламжийг өөрийн газар нутагт байгуулахыг зөвшөөрсөн улс үндэстэн гараагүй билээ.



2010 оны 11 сард Монголд Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн ерөнхий захирал Юкия Аmano ерөнхий сайд С.Батболдын урилгаар Монголд айлчлахдаа ерөнхийлөгч, ерөнхий сайдтай уулзаж, Цөмийн энергийн газарт зочлов (47). Цөмийн энергийн салбарт тоглогч болж чадаагүй манай орны хувьд 2008 оны 4 сараас хойш Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн ерөнхий захирал өөрийн биеэр 2 ч удаа морилон ирж, бас хажуугаар нь ерөнхий сайд С. Баяр, С. Батболд нар нэг нэг удаа чухалчлан очиж уулзжээ. Ердөө 2 жил 6 сарын дотор нийт 4 ч удаа дээд түвшний уулзалт болж өнгөрснийг үзвэл (48, 49) Монгол улс тус байгууллагын анхаарлын төвд орсон нь илэрхий.

Харин үнэхээр цөмийн салбарт шинээр нэгдэж буй улс орон бүрт тавих анхаарал халамж ийм сайн байдаг юм уу эсвэл 2004 оны 10 сард тус агентлагаас гаргасан тайланд (50) зөвлөсний дагуу олон улсын цөмийн хаягдлын байгууламж барих улс орныг тодруулж явсан уу гэдгийг бодолцох л хэрэгтэй юм. Тухайлбал, Японы томоохон хэвлэлүүдийн нэг “Майничи” сонины 2011 оны 7 сарын 11-ний дугаарт **“Монголд олон улсын цөмийн хаягдлын байгууламж байгуулахад Олон Улсын Цөмийн Энергийн Агентлагаас техникийн туслалцаа үзүүлж болзошгүй”** гэжээ (51).

2010 оны 12 сарын 14-нд ерөнхий сайд С.Батболд ОХУ-д айлчилж, В. Путин болон бусад албаны хүмүүстэй уулзав. Албан мэдээнд бичсэнээр (52) засгийн газрын тэргүүн нар 2009 оны 8



сард ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Д.А.Медведев нар гарын үсэг зурсан стратегийн түншлэлийг хөгжүүлэх тохиролцоог хэрэгжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар яриа өрнүүлжээ. Айлчлалын үеэр "Росатом", Цөмийн Энергийн газар, "Атомредметзолото", "МонАтом"-ын төлөөлөгчид уулзаж "Дорнод уран" ХХК байгуулах тухай гэрээ байгуулахад Монголын талаас С. Энхбат, Р. Бадамдамдин, ОХУ-аас С. Кириенко, Т. Хачатуров нар гарын үсэг зурсан байна (53).

Тэр үед ОХУ-ын ерөнхий сайд В. Путинтэй өрийн асуудлаар ярилцжээ. "Российская газета" сонинд бичсэнээс үзвэл зах зээлд шилжсэнээс хойшхи жилүүдэд "Монголросцветмет" байгууллагын төлбөр гэж 180 сая ам. долларын төлбөр хуримтлагдсан байжээ. ОХУ-ын талаас өрийн дийлэнх хэсэг буюу 97.8 хувийг уучилж, үлдсэн 3.8 сая ам. долларын өрийг үнэт цаас гаргаж дарахаар тохирсон байна. "Ингэснээр ОХУ-аас Монголд 125 сая ам. долларын шинэ зээл өгөх боломжтой боллоо" гэж ОХУ-ын Санхүү эдийн засгийн сайд А. Кудрин мэдэгджээ (54).



2011 он гармагц буюу 1 сарын 4-10-нд ерөнхий сайд С.Батболд Кувейт, Арабын Нэгдсэн Эмират улсуудаар аялав. Дэлхийн Цөмийн Энергийн Ассоциаци байгууллагын мэдээлснээр Кувейт, Арабын Нэгдсэн Эмират орнууд нь цөмийн эрчим хүч ашиглах сонирхолтой улс орнуудын тоонд ордог аж (55). С. Батболд Кувейтийн Эрхэм Дээд Эмир, бусад хүмүүстэй уулзаж

цөмийн эрчим хүч ашиглах салбарт хамтран ажиллах сонирхлоо илэрхийлжээ (56).

Дараа нь Арабын Нэгдсэн Эмират улсад очихдоо Дэд ерөнхийлөгч, ерөнхий сайд бөгөөд Дубайн захирагч Шейх Мухаммад Бин Рашид Аль-Мактумтай уулзаж АНЭУ-д цөмийн түлш нийлүүлэхийг санал болгожээ (57). Засгийн газрын албаны мэдээнд "Ерөнхий сайдын АНЭУ-д



айлчлах үед цөмийн энергийн салбарт хамтран ажиллах асуудал хөндөгдөж, манай улс Эмиратад цөмийн түлш зарах сонирхолтой байгаагаа мэдэгдсэн нь анхаарал татсан сэдэв байсан” гээд цөмийн түлш экспортлох асуудлыг ерөнхий сайдын айлчлалын “нэг гол онцлог байсан” гэжээ (58). Ингэхдээ цөмийн түлшийг ашиглаж дууссаны дараагаар хаягдлыг нь Монгол улс буцааж эргүүлэн авах тухай ч тохирчээ (51, 59, 60).

Арабын орнуудаас ирснийхээ дараахан буюу 1 сарын 21-нд ерөнхий сайд С. Батболд УИХ-ын нэгдсэн чуулганд хандаж нэг ноцтой мэдэгдэл хийсэн нь Цөмийн Энергийн хуулинд заасан **цөмийн хаягдал булшлах байгууламж байгуулахаар ажиллах болно** гэдгээ мэдэгджээ (61). Түүнчлэн ерөнхий сайдын илтгэлд “цацраг идэвхт материалыг улсын хилээр нэвтрүүлэх, тээвэрлэх”, “цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглах, устгах, булшлах”, “цөмийн хаягдлыг боловсруулах байгууламж”, “цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, боловсруулах, ашиглах, хадгалах, хаягдлыг аюулгүй болгох, тээвэрлэх” зэрэг үгс орсон байна.



Ерөнхий сайд С. Батболд 2011 оны 2 сарын 16-19-нд Сингапурт, 19-24-нд Австрали улсад айлчлав. Дашрамд хэлэхэд, Сингапур улс нь цөмийн эрчим хүч ашиглах асуудлыг судалж буй орнуудын тоонд ордог бөгөөд ерөнхий сайд Ли Цын Лунг 2010 оны 11 сард нийтэд лекц уншихдаа “Сингапур хэзээ нэг цагт цөмийн эрчим хүч ашиглана” хэмээн ярьж байжээ (62). С. Батболд Австралид айлчилсан Монголын анхны ерөнхий сайд болсон бөгөөд ураны баялгаараа дэлхийд дээгүүр ордог энэ улсын ерөнхий сайд Гиллиардтай уулзахдаа ураны салбарыг хөгжүүлэх,

энэ салбарт аюулгүй байдал, экспортын хяналтын асуудлаар хамтрах сонирхлоо илэрхийлжээ (63).

2011 оны 2 сарын 14-нд АНЭУ-ын Элчин сайд, Олон Улсын Атомын



Энергийн Агентлагийн байнгын төлөөлөгч Хамад Аль Кааби бусад зочдын хамтаар Монголд айлчилж, шадар сайд М. Энхболдтой уулзжээ (64). Уулзалтан дээр ГХ-ны тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд А. Ундраа ч

байлцсан байна. Мэдээнээс үзвэл Эмиратын зочид ерөнхий сайд С. Батболдын айлчлалын үеэр яригдсан цөмийн түлшээр хангах гэрээг хэлэлцэх зорилготой Монголд ирсэн аж (65).

Хятадын ГХ-ийн сайд Ян Жэчи

2011 оны 2 сарын 24-25-нд

айлчлахдаа Ц. Элбэгдорж,

С.Батболд, Г. Занданшатар нартай

уулзаж, Вэнь Зябаогийн айлчлалын

үеэр тавигдсан хамтран ажиллах

амлалтыг сануулж, улам

гүнзгийрүүлэх талаар ярилцсан

байна. Ян Жэчи ГХ-ны сайд


Г.Занданшатартай хэлэлцээ хийж,

хоёр орны хамтын ажиллагааны баримт бичгүүдэд гарын үсэг зуржээ (66, 67).



2011 оны 3 сарын 23-25-нд ерөнхий сайд Солонгос улсад айлчлахад

Г.Занданшатар, С. Энхбат болон бусад хүмүүс дагалдан явсан байна (68).



Айлчлалын үеэр Солонгосын Боловсролын Яамтай Цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, С. Энхбат гарын үсэг зуржээ. Үүнд бага болон дунд оврын цөмийн реактор, мөн цөмийн технологийн аюулгүйн байдал болон цөмийн хаягдлыг зохицуулах асуудлаар хүний нөөц солилцох, техникийн мэдээлэл солилцох

асуудлаар хамтран ажиллахаар тохиролцов (69, 70). Харилцан ойлголцлын

санамж бичгийг 2009 оны 4 сард анхлан байгуул С. Энхбат гарын үсэг зурсан тухай мэдээ Солонгос хэл дээр байх ажээ (111).

Ингэж байхад 3 сарын 31-нд АНУ-ын Цөмийн Энергийн бодлогын нэгэн томоохон хурал дээр Эрчим хүчний албаны дарга **Ричард Стратфорд гэгч Монголд олон улсын цөмийн хаягдал булшлах яриа явагдаж байгаа** гэж ярьснаар (71) аалзны тор шиг хичээнгүйлэн хэрж байсан байсан бохир бизнес дэлхий нийтэд ил тод болов. Гэвч Монголын эрх баригчид шантарсангүй, асуудлыг үгүйсгэхийн зэрэгцээ зорьсноо биелүүлэхээр хичээсээр.

2011 оны 4 сарын 4--6-нд Монгол Улсын ГХ-ны сайд Г.Занданшатар Арабын Нэгдсэн Эмиратад айлчилж С. Батболдын айлчлалын амлалтуудыг бататгажээ. Тэрвээр АНЭУ-ын ГХ-ийн сайд Шейх Абдулла бин Заид Аль-Нахъяан-тай уулзаж, хоёр орны харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлэх, эрчим хүч, уул уурхайн салбарт хамтран ажиллахаар хэлэлцэж тохирчээ. Мөн Эмиратын Цөмийн эрчим хүчний корпорацийн удирдлагатай уулзаж, хамтран ажиллахаар ярилцсан байна (72).

Гэвч цөмийн хаягдлын асуудал намжсангүй. 2011 оны 5 сарын 9-нд Японы урьдаа барьдаг томоохон хэвлэлүүдийн нэг болох 5.5 сая гаруй тоогоор



хэвлэгддэг “Майничи Шинбун” сонины сэтгүүлч Монголд цөмийн хаягдлаа хаяхаар АНУ, Япон, Монголын түшмэд гэрээ хэлэлцээр хийж буй нууц хуйвалдааныг дахин илчлэв. Үүнд цочирдсон Г.Занданшатар 2011 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Японы Элчин сайд Т.Кидокоротой уулзаж, “Майничи” сонинд гарсан нийтлэлийг талаар ярилцаж (73), асуудлыг намжаах арга сүвэгчилж,

баримтыг үгүйсгэсээр боловч цаагуураа шаргуу ажилласаар л байв.

- **Ц. Элбэгдоржийн АНУ-д хийсэн айлчлал ба Обамагийн дэмжсэн “Монголын Цөмийн Санаачлага” гэж юу вэ?**

2011 оны 6 сарын 14-20-нд Ц. Элбэгдоржийг АНУ-д айлчлахад Г.Занданшатар, Лу. Болд, Ч. Сайханбилэг нараас гадна “МонАтом”-ын Р.Бадамдамдин дагалдаж явсан нь сонирхол татаж байна (74). Ерөнхийлөгч Сан-Францискогийн Монголчуудтай уулзахад тэр орчимд оршин суудаг Л. Мөнхтөр гэгч залуу Монголын газар нутгийг Солонгост зарсан эсэх болон цөмийн хаягдал булшлах талаар ерөнхийлөгчөөс тодруулахаар асуужээ (75).

Л. Мөнхтөр “Монгол улсын нутагт цөмийн хог, хаягдлыг булшлах гэсэн гадныхантай манай дарга нар, эрх мэдэлтнүүдийн хийсэн нууц гэрээ, хэлэлцээр бараг гарын үсэг зурагдахаас өмнөх түвшинд очсон асуудал сөхөгдсөн. Энэ үнэхээр Монгол улсын баримтлах бодлого мөн үү?” гэж асуугаад монгол англиар **“Монгол нутаг атомын хаягдлын сав биш!”** гэсэн уриа бичсэнээ ерөнхийлөгчид өргөн барихад нь урьдаас нь “эгээтэй л цөмийн хаягдал гарт нь атгуулах гэсэн юм шиг эгдүүцэн цааргалж”, комиссарууд нь халхлаад ойртуулсангүй.



Солонгост газар нутгаа худалдсан тухай түүний асуултанд Ц. Элбэгдорж “Дорнод аймагт намайг томилолттой явж байхад аймгийн засаг дарга дуудаад - “Алив ерөнхийлөгчөө та бидний ард фон болоод зогсч бай, гарын үсэг зурах ёслол болж байна” гэж гуйсан. Тэгэхээр нь би юуг нь ч мэдээгүй ард нь зогсоод өгсөн чинь дараа нь газраа Солонгосчуудад зарсан гэсэн иймэрхүү юманд холбогдчихлоо” гэж хариулсан байна (75). Америкт амьдардаг залуу ерөнхийлөгчид ноцтой асуулт тавьж, таагүй байдалд оруулсан явдлын тухай нийтэд мэдээлэлгүй хав дарсан тул АНУ-д ч, Монголд ч хүмүүс мэдэлгүй өнгөрчээ.

Сан-Францискогоос Ц. Элбэгдорж Вашингтон ДС орж, шагнал авч бас ерөнхийлөгч Обаматай ганцаарчлан ярилцах завшаан эдэлсэн гэх. Уулзалтын дараа гарсан хоёр орны хамтарсан мэдэгдэлд “АНУ **Монголын Цөмийн Санаачилгыг** хүлээн зөвшөөрч дэмжихийн зэрэгцээ...” гэжээ (76).



Чухам “**Монголын Цөмийн Санаачилга**” (**Mongolian Nuclear Initiative**) гэгч энэ төсөл санаачлага нь юун тухай болох хийгээд энэ төслийг хэн боловсруулсан талаар хийсэн бяцхан судалгаагаа та бүхэнд танилцуулья.

Хэн, хэзээ энэ төслийг боловсруулж санаачилсан нь тодорхойгүй ч Стэнфордын их сургуулийн цахим сайт дээр Агваанлуvsангийн Ундраа “**Олон талын хамтын ажиллагааны аргаар цөмийн зэвсгээр хөөцөлдөх эрсдлийг бууруулах: Зүүн хойт Ази ба Монголын Цөмийн Санаачлага**” гэсэн сэдвээр илтгэл тавина гэсэн зар мэдээ байх юм (77).

Тайлбарлаваас: Олон улсын эрдэмтэд цөмийн хаягдлыг дахин боловсруулах асуудлыг 60 гаруй жил судалж буй ч осол аюулгүй, өртөг зардал багатай, баталгаатай технологийг өнөөг хүртэл нээж олж чадаагүй байна. Эрдэмтдийн үзэж буйгаар дахиад 50-100 жилдээ ч энэ асуудлаар шинийг бүтээж чадахгүй гэх. Сүүлийн тавин жилд хаягдал дахин боловсруулах 20 орчим үйлдвэр байгуулсан ч өнөөдөр үйл ажиллагаа явуулж буй нь гарын таван хуруунаас ч цөөн, 12 нь бүрмөсөн хаагдсан гэдэг баримт эрхбиш нэгийг бодогдуулна биз ээ (78, хуудас 2).

Цөмийн эрчим хүч ашиглагч орнууд ч хаягдал дахин боловсруулахыг төдийлэн сонирхдоггүй аж. Тухайлбал, Финлянд улс гэхэд дотоодын цөмийн түлшний хаягдлаа үүрд булшлахаар Онкало гэдэг агуулахыг Олкилуото арал дээрээ барьж байна (79, 80). А. Ундраа, П. Алтангэрэл зэрэг хүмүүс цөмийн түлшний хаягдлыг “үнэт баялаг” гэж нэрлэж байгаа ч үнэхээр дахин боловсруулах боломжтой баялаг мөн байсан бол Финляндчууд хаягдлаа газрын гүнд 500 метрийн дор хэзээ ч ухаж авах боломжгүйгээр булшлах байсан гэж үү? Бас “хэзээ ч битгий уудлаарай” гэсэн захиасаа үр хойчдоо хүргэх талаар “тархиа гашилгаж” суух байсан уу? (80)

Цөмийн хаягдлыг дахин боловсруулахад ялгардаг плутонийг цөмийн бөмбөг хийхэд ашигладаг байна. Түүх сөхвөл “Энхийн атом” хөтөлбөрийн хүрээнд Америкчуудаас цөмийн түлш дахин боловсруулах арга сурсан Энэтхэгчүүд анхныхаа ялгасан плутониор 1974 онд цөмийн бөмбөг хийж туршжээ. Америкийн иргэд, улс төрийн хүчнийхэн эдийн засгийн үр ашиггүй, осол аваар ихтэй, зэвсгээр хөөцөлдөх явдлыг дэмжсэн гэж цөмийн хаягдал дахин боловсруулах төслийг эртнээс эсэргүүцэж байсан тул ерөнхийлөгч Картер дахин боловсруулахыг 1977 онд зогсоожээ (78, хуудас 102).

Цөмийн зэвсгээр хөөцөлдөх явдлыг хязгаарлахын тулд тус салбарын томоохон тоглогчид технологийн нууцыг хадгалах, түүхий эд, хаягдлыг хянах арга хэмжээ авдаг. АНУ гэхэд бусад орнуудад цөмийн түлш, цөмийн реактор борлуулахдаа цөмийн түлшний хаягдал алдагдах, террористуудын гарт орох, цөмийн түлшний хаягдлаас плутони ялгаж, зэвсгээр хөөцөлдөхөөс сэрэмжилж тусгай гэрээ байгуулдаг. Тухайлбал, Өмнөд Солонгос, Тайвань, Япон зэрэг улсуудтай байгуулсан “цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах хамтын ажиллагааны гэрээ” буюу товчилбол “123” гэдэг гэрээнд “Америкт үйлдвэрлэсэн цөмийн реактор болон ураны түлшийг ашигласан нөхцөлд үйлдвэрлэлийн явцад гарсан түлшний хаягдалд АНУ-аас хяналт тавина” гэж тусгажээ (81).


Анхлан бүх хаягдлыг нь эргүүлж авахаар төлөвлөж байсан бололтой. Харамсалтай нь Невада мужийн Якка ууланд цөмийн хаягдлаа булшлах үндэсний төлөвлөгөө бүтэлгүйтсний улмаас Америкчууд гадны бүү хэл дотоодод хуримтлагдсан цөмийн түлшний хаягдлаа хэрхэхээ мэдэхгүй тэвдэж байна. Солонгос, Тайвань, Японы ард түмэн цөмийн түлшний хаягдлыг өөрсдийн улсын нутаг дэвсгэр дээр урт хугацаагаар хадгалах, булшлахыг эрс эсэргүүцэж, хаягдлыг эргүүлж авах эс бөгөөс өөрсдийн мэдлээр захиран зарцуулах эрх олгохыг шаардах болсноор АНУ ацан шалаанд орсон аж (81).

Ийм нөхцөлд **“Зүүн Хойт Азийн бүс нутагт цөмийн зэвсгээр хөөцөлдөх эрсдлийг олон улсын хамтын ажиллагааны үр дүнд бууруулах”** гэдгийг Зүүн Хойт Азийн нэг улсад бүс нутгийн цөмийн хаягдал түлшийг хадгалах байгууламж

байгуулж, Тайвань, Солонгос, Японы цөмийн түлшний хаягдлыг хадгалахыг хэлж байна гэж ойлговол зүйтэй юм. “**Монголын Цөмийн Санаачлага**” гэхээр бусдын хаягдлыг хадгалж өөрийгөө золиослох тэр улс нь Монгол болж таарч байна.

Энэ талаар зарим нэг баримт нотолгоог дурдвал:

Баримт 1: Олон Улсын Атомын Энергийн Агентлагаас 2004 оны 10 сард гаргасан “Олон улсын цацраг идэвхт цөмийн хаягдлын байгууламж байгуулах



тухай” тайлангийн 3, 15, 22-р хуудсанд цөмийн зэвсгээр хөөцөлдөх эрсдлийг бууруулах арга замуудын талаар маш тодорхой бичжээ (50). Ингэх ердөө л хоёрхон арга зам байдаг ба нэг нь нөгөөгийнхөө салшгүй хэсэг бололтой. Эхнийх нь аль нэг улс оронд олон улсын цөмийн хаягдлын байгууламж байгуулах, дараагийнх нь аль нэг улс цөмийн түлш зээлдүүлэх үйлчилгээг даалгах (цөмийн түлш үйлдвэрлэж, бусдад хэрэглүүлээд хаягдлыг буцааж авч нутагтаа цөмийн хаягдлын байгууламжиндаа булшлах) гэсэн аргууд байдаг ажээ.


Анзаарвал, “Монголоос гаралтай ураныхаа хаягдлыг, гадаадад гаргасан цөмийн түлшнийхээ хаягдлыг бид эргүүлж авна, тийм олон улсын жишиг байдаг” гэх яриа сүүлийн үед газар аваад байгаа. Ураны нөөцтэй Австрали, Канад, АНУ хаягдлаа авахгүй байхад зөвхөн Монголд үйлчилдэг энэ дүрэм хаанаас гаралтайг тааж цөхөх юмгүй. Зөвхөн цөмийн түлш зээлдүүлэх буюу “түлшний банк” хэмээх үйлчилгээг үзүүлвэл ийм шаардлага тавигдана.

Баримт 2: Наадмын дараахан “Майничи” сонинд цөмийн түлш үйлдвэрлэж, хаягдал түлшийг булшлах тухай Япон-АНУ-Монгол 3 улсын гэрээ байгуулах гэж байгаа тухай мэдээ гарав. Тус мэдээнд “цөмийн түлшний иж бүрэн үйлчилгээ” гэгчийг үзүүлэх манай гаригийн анхны тогтолцоог Монголд байгуулна” гэж бичжээ (51). “Иж бүрэн үйлчилгээ” гэдэг гоёмсог нэрний цаана уранаа олборлож, түлш болгож зараад, эцэст нь хорт хаягдлыг нь авч булшлахыг хэлж буйг анхаарна уу. “Цөмийн түлшний иж бүрэн үйлчилгээ”, “цөмийн түлш зээлдүүлэх”, “цөмийн түлшний банк” гэдэг олон нэрний цаана уранаа олборлож борлуулчихаад ялгарсан хорт хаягдлыг нь эргүүлж Монголдоо булшлах нэг л төлөвлөгөө явж байгаа аж.

Баримт 3: Сүүлийн үед “цөмийн хаягдал биш үнэт баялаг”, “бусад орнууд өндөр үнээр булаалдаж авдаг”, “цөмийн хаягдал хор хөнөөлгүй, харин ашигтай сайхан бизнес” гэх зэрэг мэдэгдлийг ГХ-ны элчин сайд А. Ундраа, УИХ-ын гишүүн

П. Алтангэрэл, О. Чулуунбат нарын албаны хүмүүс удаа дараа хийх болсон билээ (82,83, 84, 85).

Тэгвэл бодит байдал ямар байна вэ? Япон, Солонгос, Тайвань зэрэг манай ойрын хөршүүдээс эхлээд, бүх дэлхийн улс орнууд бусдын бүү хэл өөрийн цөмийн түлшний хаягдлаас цэрвэдэг (80). Дотоодын цөмийн түлшний хаягдлаа



дахин боловсруулах боломжгүй болохоороо АНУ, Финлянд, Швед улсууд 400-500 метрийн гүнд үүрд булшлахаар агуулах байгууламж байгуулж байна (79, 81, 86).

Харин ерөнхийлөгч Ц. Элбэгдоржийг АНУ-д айлчлахын өмнөхөн АНУ-ын Конгрессийн дэргэдэх судалгааны албанаас гаргасан Монголын тухай тайланд: “Гадны цөмийн түлшний хаягдал хадгалах асуудал нь Монголын улс


төрийн эмзэг асуудлын нэг бөгөөд бусад орнуудын нэгэн ижлээр цөмийн түлшний хаягдал хадгалахын эсрэг тэмцэл Монголд хүчтэй өрнөж байна. Гэвч зарим шинжээчдийн үзэж буйгаар Монголын байр суурь өөрчлөгдөх боломжтой аж. Цөмийн хаягдал түлшин дэх плутонид асар их энерги агуулагддаг тул **цөмийн хаягдал түлшийг “цөмийн хаягдал” гэлгүй, өөр нэр өгчихөж болно** гэж нэг шинжээч тэмдэглэжээ. Зарим нэг Монгол шинжээчид ч олон улсын цөмийн түлшний хаягдлыг хадгалах гэрээ байгуулснаараа Орос улстай эдийн засгийн харилцаагаа өргөжүүлж, Хятадтай харилцах эдийн засгийн харилцаагаа тэнцвэртэй болгох боломжтой хэмээн үзэж байна. Ингэсэн тохиолдолд, Монголд олборлосон уранаар Орост түлш үйлдвэрлээд, эцэст нь гарсан **цөмийн түлшний хаягдлыг нутагтаа хадгалахыг Монгол улс зөвшөөрч болзошгүй юм**” гэж бичжээ (87).

Дээрхээс үзвэл өнөөх л цөмийн түлшний банк байгуулах үзэл санаа гарч байна. Өөрөөр хэлвэл, Монгол уранаа олборлож, ОХУ-д түлш үйлдвэрлүүлээд, гадагш борлуулаад, хаягдлыг нь нутагтаа булшлахын тулд хорт хаягдлыг “үнэт баялаг”, “түүхий эд” нэрээр оруулж ирэх боломжтой ажээ.



Баримт 4: 2010 оны 5 сарын 31--6 сарын 1-ний хооронд Малайзийн Путражая хотод Токиогийн их сургууль (Тодай) болон Малайзийн Universiti Kebangsaan гэдэг сургуулиудаас хамтран зохион байгуулсан нэгэн семинар болжээ (88). Сэдэв нь “АСЕАН-ы орнуудад цөмийн эрчим хүч ашиглахад анхаарах асуудлууд: Цөмийн эрчим хүчний салбарыг хөгжүүлэхэд бүс нутгийн хамтын ажиллагаа хэр ач холбогдолтой вэ?” гэсэн байв. Семинарт Австрали, Хятад, Тайвань, Энэтхэг, Япон, Казахстан, Монгол, Солонгос, Сингапур, АНУ, Вьетнам зэрэг орнуудын 30 гаруй төлөөлөгчид оролцжээ.

Хуралдааны 3-р хэсэг нь “Ази Номхон Далайн бүсийн цөмийн энергийн хөтөлбөрүүдийн бүс нутгийн хамтын ажиллагаа” гэдэг нэртэй байв. Хамгийн эхэнд илтгэл тавьсан Тайваний төлөөлөгч тус улсын цөмийн хөтөлбөрийн нэн тэргүүний тулгамдсан асуудал нь цөмийн түлшний хаягдлаа хэрхэх тухай асуудал гэдгийг онцлоод энэ асуудлыг яаравчлан шийдэхгүйгээр Тайвань хөтөлбөрөө үргэлжлүүлэх боломжгүй болоод байна гэжээ. Тэрбээр Ази Номхон далайн бүс нутгийн цөмийн түлшний хаягдлыг агуулах байгууламж, өндөр идэвхтэй цөмийн хаягдал хадгалах газруудыг байгуулах асуудлыг хамтын ажиллагааны нэн тэргүүний зорилго болгох нь зүйтэй гэж хэлжээ (88).



Дараахан нь Монголын оролцогч илтгэл тавихдаа Монголын Цөмийн Санаачлага (“Mongolian Nuclear Initiative”) гэгч төсөл нь байгалийнхаа арвин нөөц баялагт түшиглэн технологийн өндөр түвшинд гарах зорилготой гэж танилцуулжээ. Илтгэгч ярихдаа төслийн нарийн төлөвлөлт хараахан бэлэн болоогүй хэдий ч **Монголчууд нийлүүлсэн цөмийн түлшнийхээ хаягдлыг эргүүлэн авах болон “өлгийнөөс оршуулга” хүртэл** (“cradle-to-grave” буюу уран олборлохоос авахуулаад ашигласан цөмийн түлшний хаягдлыг авч булшлах хүртэлх) үе шатуудыг хариуцах нь баталгаатай болсон гэж ярьсан байна. Түүнчлэн Монгол улс түлш үйлдвэрлэх байгууламж байгуулалгүй олон талт хамтын ажиллагаанд түшиглэх саналтайг ч бас дурьджээ (88).

Семинарын төгсгөлд гарсан санал дүгнэлтүүдийг жагсааснаас үзвэл Тайвань, Солонгос, Япон зэрэг орнуудад цөмийн хаягдал түлшний менежментийн асуудал дээр бүсийн бусад орнуудын туслалцаа дэмжлэг онцгой шаардлагатай байгааг дурьдаад цөмийн хаягдал түлшний менежмент гэдгийг “1) бүсийн цөмийн хаягдал түлшийг түр агуулах байр; 2) бүсийн цөмийн түлшний төв байгуулах гэж ойлгоно” гэж бичжээ (88). Сүүлчийнхийг тайлбарлавал Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн санал болгосон цөмийн түлш зээлдүүлээд эргүүлж хаягдлыг нь авдаг үйлчилгээ үзүүлэх төв (“цөмийн түлшний банк”) байгуулах санаатай ижил

ажээ. Чухам энэ саналыг П. Алтангэрэл гишүүн АНУ-аас ирэхдээ сурч мэдсэн зүйл гэж ярьсан билээ (46).

- **Өнгөрсөн зуны айлчлалууд буюу дарга нарын сэм алга бололт**

Өнгөрсөн зуны туршид Монголд айлчилсан Энэтхэг, Солонгос, Япон, АНУ-ын төрийн өндөр албан тушаалтнуудын айлчлалын үеэр цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах асуудал удаа дараа хөндөгдөж, заримтай нь гэрээ хэлэлцээр ч хийгдсэн (89, 90, 91, 92). Тухайлбал, Солонгосын ерөнхийлөгчтэй уран олборлох, боловсруулах салбарт хамтран ажиллах санамж бичиг үйлдсэн ч ерөнхийлөгчийн <http://president.mn> сайт аанай л дурьдсангүй (92). С. Батболд сүүлийн 23 жилд анх удаагаа Монгол улсад айлчилж ирсэн Энэтхэгийн ерөнхийлөгчид бараалхсан ба эрчим хүч, цөмийн энергийг энхийн зорилгод ашиглах хамтын ажиллагааг эрчимжүүлэх саналтай байгаагаа эрхэм зочин дуулгажээ (93). Финлянд улс дэлхийд анхны цөмийн хаягдлын агуулах барьж байгаа туршлагатай аж. Ерөнхийлөгчийн Ц. Элбэгдоржийн аялсан улсуудаас Украин нь АЦС-тай, Литв нь цөмийн хөтөлбөртэй болох хүсэлт гаргасан улс байна (55).

Үүний зэрэгцээ манай төрийн өндөр албан тушаалтнууд сэм алга болох явдал сүүлийн үед гарах боллоо. Тухайлбал, 2011 оны 8 сарын дундуур ерөнхий сайд С.Батболд Хэнтийд амрана гэж мэдээлчихээд Америк явсан ба ямар зорилготой явсныг нь тойрон хүрээлэгчид нь тас нууж байгаа тухай “Өдрийн сонинд” бичиж байв (94, 95). Зарим эх сурвалжид ерөнхий сайд “хувийн ажлаар АНУ-д очсон” гэх боловч “гэр бүлтэйгээ биш цөөн хэдэн зөвлөхөө дагуулаад амрахаар одсон” гэх аж.



Мөн ерөнхий сайдыг “АНУ-д сургах хүүхдийнхээ сургуулийн асуудлыг хөөцөлдөхөөр явсан” (94) гэсэн гэнэн тайлбарыг уншихад хүүхдээ эрдэм сургахаар авчирч буй хөдөө сумын малчны дүр нүдэнд бууж байлаа. АНУ-д сургуульд ороход аав ээж нь хөөцөлддөггүй, харин тухайн оюутны бичсэн эссе зохион бичлэг, шалгалтын дүн чухал байдаг. Тэгээд ч сургуулийн асуудал аль хавар шийдэгдсэн тул өдийд зөвлөхтэйгээ очоод ч нэмэргүй болсон байх учиртай билээ.

Тэгвэл Цөмийн Энергийн газрын дарга С. Энхбат ч бас гэнэтхэн ор сураггүй алга болж ерөнхий сайдын уур уцаарыг хүргэсэн асуудал саяхан гарлаа. Лав л 8 сарын 25-ны мэдээнд “Засгийн газрын хуралдаанд ажлаа танилцуулах ёстой С.Энхбат хуралд хоёр ч удаа ирээгүй” гэж бичсэн байна (96). Цөмийн хаягдлыг



Монголд булшлах тухай мэдээг нам үгүйсгэх ёстой ганц хүн нь С. Энхбат болохоор хурал дахин дахин хойшлогдсоор байв. Ерөнхий сайд С.Батболд “ажлаа хийж чадахгүй байгаа Цөмийн Энергийн газрын удирдлагатай хатуу хариуцлага тооцно” гэж айлгасан ч (96) С. Энхбат “том толгойлсоор” хуралдаанд 8 сарын 31-нд иржээ.

Ерөнхий сайдыг хүлээлгэсэн С. Энхбат “Намайг хэн ч дуудаагүй” гээд хээв нэг ярилцлага өгснийг үзвэл (97) лав л өдөр тутмын хэвлэл уншдаггүй газарт байсан гэж бодогдох. Монгол нутгийн хаана ч байсан гар утас ажиллахгүйн зовлон арилсан тул 2-3 хоногтоо багтаад хүрээд ирэх боломжтой баймаарсан даа.

Ерөнхий сайд С.Батболд зөвлөхүүдээ дагуулаад хаана хэнтэй уулзаж яваад ирэв? С. Энхбат хаана хөл хоригдсон болоод даргынхаа дуудлагаар хүрч ирсэнгүй вэ?

Америкийн newstmax.com мэдээллийн сайт дээр 2011 оны 7 сарын 18-нд гарсан мэдээ нууцыг тайлж байна (98). Тус мэдээнд Монголд олон улсын цөмийн хаягдлыг хадгалах асуудалд АНУ оролцож буй тухай тодорхой бичээд “энэ оны 8 сард **Монголын засгийн газрын төлөөлөгчид** Айдахо мужийн Үндэсний Цөмийн Энергийн Лабораторид (Idaho National Nuclear Laboratory) зочилж, цөмийн хаягдал булшлахаар төлөвлөж байсан Невада мужийн Якка уулын байгууламжинд ашиглахаар бүтээсэн цөмийн технологийг судална” гэжээ. Эхний асуултын хариу энэ бололтой.

Харин АНУ-д байдаг Монголчуудын мэдээлснээс үзвэл 8 сарын сүүлээр Монголоос ирсэн хэсэг хүмүүс Вашингтон мужийн Ричланд хотод байрлах Номхон Далай- баруун хойт бүсийн Үндэсний Лабораторид (Pacific Northwest National Laboratory) айлчилж, сургалтанд сууж байгаа гэнэ. Тэдний сургалтыг Virginia Harter гэдэг эмэгтэй хариуцаж байгаа аж. Америкт амьдардаг Г. орчуулагч нарын ахлагчаар ажиллаж буй Ламжавын Мөнх-Эрдэнэ гэгч залуутай утсаар холбогдож лавлахад “Монголоос хэд хэдэн байгууллагаас хүмүүс ирсэн, цацраг идэвхт бодис тээвэрлэх,



илрүүлэх сургалтанд сууж байгаа” гэдгээс илүү мэдээлэл өгөхөөс татгалзсан байна.

Татвар төлөгчдийн мөнгөөр албан ажлаар ирсэн төрийн албан хаагчид мэдээллийг ингэтлээ нуух нь хэнд ч сэжигтэй санагдмаарсан. Ямартаа ч Цөмийн Энергийн газрынхан, тэр дундаа С. Энхбат дарга тэнд байсан байж таарлаа.

- **Ц. Элбэгдорж, С. Батболдын үед болж өнгөрсөн үйл явдлууд:**

- Монголын эрх баригчид, ялангуяа ерөнхий сайд С. Батболд, ураны салбарт хамтрах түншүүдийг уйгагүй эрэлхийлэхдээ урьд хөл тавьж үзээгүй Австрали тив хүртэл оржээ. Хайгуулын явцад ОХУ, Хятад, Канад, Австрали, Сингапур, Кувейт, Арабын Эмират, Солонгос, Япон, Украин, Литв, Финлянд, АНУ, Энэтхэг зэрэг орнуудад айлчилж, ураны салбарт хамтран ажиллах, цөмийн түлш нийлүүлэх санал тавьж байжээ.

Үр дүнд нь ОХУ, Япон, Франц, Энэтхэгтэй гэрээ хэлэлцээрээ шинэчилж, Хятад, Солонгос, Арабын Эмират, АНУ зэрэг улсуудтай ураны салбарт хамтран ажиллах санамж бичиг үзэглэсэн байна.

- С. Батболд Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн удирдлагатай 2 удаа уулзсан байна. Ерөнхий захирал Юкия Амано өөрийн биеэр 2010 оны 11 сард Монголд айлчилжээ. Бусад хурал цуглаан дээр ч уулзалдах боломж гарч байсан бололтой.
- 2008-2010 оны хооронд Монголын эрх баригчид олон улсын цөмийн хаягдлыг булшлахыг зөвшөөрчээ. **Нотолгоо:** 2010 оны 6 сарын 21-нд “The Asia-Pacific” (“Ази- Номхон Далай”) эрдэм шинжилгээний сэтгүүлд Вашингтон ДС-д байрлах Цөмийн зэвсгээр хөөцөлдөхийн эсрэг төвийн судлаачид болон Олон улс судлалын Монтерейн Институтын хүндэт профессор, Корнеллийн их сургуулийн профессор нарын хамтын бүтээл болох өгүүлэл нийтлэгджээ (99). Өгүүлэлд Олон Улсын Атомын Энергийн ерөнхий захирал Мохамед Эль Барадей 2003 оноос олон улсын цөмийн хаягдлын байгууламж байгуулахыг уриалсан тухай бичжээ. Тун саяхныг хүртэл энэ хариуцлагыг саналаараа хүлээх улс орон гарахгүй байсан ба **Монгол улс ганцаараа цөмийн хаягдлын байгууламжийг нутагтаа байгуулах хүсэлт гаргасан гэсэн байна.**
- Цөмийн Энергийн газрын дарга С. Энхбат “**цөмийн хаягдал Монголд булшлах тухай албан бусаар ярьсан нь үнэн шүү дээ**” гэж 8 сарын 31-нд Засгийн газрын хуралдаанд орж, бие нь муудахын өмнө сурвалжлагчид ярьжээ (97). Ингэж хэлснээрээ тэрбээр АНУ-ын Төрийн Департаментийн

албаны дарга Ричард Стратфорд, Японы Гадаад Хэргийн тэргүүн дэд сайд Чиаки Такахаша, Японы Гадаад хэргийн сайд Такияки Мацумото нартай нийлээд үнэнийг хүлээсэн дөрөв дэх албан тушаалтан боллоо.

Ричард Стратфорд гэгч ноёнтон 2011 оны 3 сарын 29-нд болсон олон улсын хурал дээр Монголд цөмийн хаягдал агуулах тухай ярьсан (71). Японы Гадаад Хэргийн тэргүүн дэд сайд Чиаки Такахаша 2011 оны 5 сарын 9-нд болсон хэвлэлийн бага хурал дээр “Япон улс нь АНУ болон Монгол улстай цөмийн хаягдал булшлах тухай албан бус хэлэлцээр хийж байсан нь үнэн” гэж мэдэгдсэн (100). 2011 оны 7 сард Японы Гадаад Хэргийн сайд Такеаки Мацумото “цөмийн хаягдлыг Монголд булах байгууламж барих төслийн талаар Балид болсон уулзалтан дээр ГХ-ны сайд Г. Занданшатарас лавлаж асуусан бөгөөд гэрээ хэлэлцээр ямар нэг үр дүнд хараахан хүрээгүй байна” гэж ярьжээ (101).

- “Монголын Цөмийн Санаачлага” хэмээх нэртэй Зүүн өмнөд Азийн орнуудад цөмийн түлш зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэх төслийг Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж эхэлжээ. Энэ төслийг дагаад цөмийн хаягдал агуулах байгууламж барих хэрэгцээ гарсныг ерөнхий сайдын 2011 оны 1 сарын 21-нд УИХ-д хандаж хэлсэн үг гэрчилнэ (61).

Чухамдаа уранаа олборлож, чадвал баяжуулаад, ОХУ-д захиалж, түлш үйлдвэрлүүлээд, гадагш гаргаж зараад, хог хаягдлыг нь эргүүлэн авч нутагтаа булшлах нь (87) хэнд ашигтай вэ? Цөмийн хаягдалгүй цэвэр энерги ашиглах Тайвань, Япон, Солонгос мэтийн Азийн орнуудад ашигтай. Эрчим хүчний хэрэгцээ ихтэй, АЦС нэмж барихаар төлөвлөж буй Хятадад ч ашигтай. Цөмийн түлш захиалгаар үйлдвэрлэх ОХУ-ад ашигтай. Оросын Ангарскийн цөмийн түлшний банк хуучин ЗХУ-ын харъяа орнууд, зүүн Европын орнууд, Иранд цөмийн түлш зээлдүүлэх үйлчилгээ үзүүлдэг тул зах зээл хуваагдсан, өрсөлдөөн үгүй. Харин газрын хэвлийд гэм хоргүй хадгалагдаж байсан ашигт малтмалаа ухаж зарчихаад, оронд нь хэдэн зуун мянган жилээр үхлийн хор ялгаруулах цөмийн хаягдал авсан Монголд ашиггүй нь тодорхой.

- Арваадхан хоногийн өмнө Монгол улсын ерөнхий сайд Сэлэнгэ аймгийн сурагч хүүгийн цөмийн хаягдлын эсрэг уриалгад гарын үсэг зурсан бол ерөнхийлөгч Ц. Элбэгдорж долоохон хоногийн дотор 3 туслахаараа өөрийгөө цөмийн хаягдлын асуудалд холбоогүй гэж зарлуулж, ярилцлага өгүүлжээ (102). Гэвч яриа шуугиан намжихгүй байсан уу, өнгөрсөн долоо хоногт ерөнхийлөгч, ерөнхий сайд хоёр хамтарч “Цөмийн хаягдлын тухай” зарлиг гаргажээ (103). Зарлигт:

1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цөмийн хаягдлыг хадгалах, түр байршуулах, булшлах зорилгоор импортлох, хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагаа явуулахыг хориглосон Монгол Улсын хууль тогтоомжийн зүйл, заалтыг тууштай мөрдөж ажиллах.

2. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зохих шийдвэргүйгээр цөмийн хаягдлын асуудлаар бусад улс орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, Монгол Улсын нэрийн өмнөөс аливаа яриа хэлэлцээ хийх, гэрээ хэлцэл байгуулах, баримт бичиг үйлдэхийг хориглох--- гэсэн чухал заалтуудыг оруулжээ. Гэвч бодит байдалд зарлиг хэрэгжих боломжгүй гэж үзэж байгаагаа тайлбарлаваас:

1) Өнөөдөр Монгол улсад мөрдөж буй Цөмийн Энергийн тухай болон Аюултай хог хаягдлыг импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хуулиар гадны цөмийн хаягдлыг Монголд булшлах бүрэн боломжтой байна.

Яаравчлан баталсан 2009 оны Цөмийн Энергийн тухай хуулинд цөмийн хаягдлыг хадгалах, тээвэрлэх, булшлах тухай заасан бөгөөд цөмийн ямар хаягдлыг өөрийнх гэх бас алийг нь хүнийх гэх талаар хуулийн нарийн тодорхойлт алга. Өнөөдөр Монголын уранаар хийгдсэн бүтээгдэхүүнээс (цөмийн түлшнээс) гарсан бүх хаягдлыг “дотоодын хаягдал” гэж сурталчлах хандлага давамгайлж байгаа тул харийн цөмийн хаягдлыг Монгол нутагт булшлах боломж нээлттэй байна.

Харин 2000 оны 11 сарын 03-нд баталдсан Аюултай хог хаягдлыг импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хуулиар “аюултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор Монгол Улсад импортоор оруулах, улсын хилээр дамжуулан тээвэрлэхийг хориглоно” гэж заасан ч энэ хуулийг аргалах арга нь цөмийн хаягдлыг “хаягдал биш харин 50, 100, 10 мянган жилийн дараа асар өндөр үнэ хүрэх баялаг, үнэт түүхий эд” нэрээр Монголд оруулж ирж хадгалах бололцоотойг АНУ-ын Конгрессийн тайланд тодорхой дурьджээ (87).

2) Зарлигаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн (ҮАБЗ) шийдвэргүйгээр цөмийн хаягдлын асуудлаар яриа хэлэлцээ хийхийг хориглосон байна. Гэвч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн нь Ц. Элбэгдорж, харин гишүүд нь УИХ-ын дарга Д. Дэмбэрэл, ерөнхий сайд С. Батболд нар байх тул “чононд хонио хадгалуулсан” үлгэр санаанд орж байх... Үнэндээ сүүлийн 3 жилд Монгол улсын байгуулсан цөмийн гэрээ хэлэлцээр бүрт ерөнхийлөгч эсвэл ерөнхий сайд, заримдаа хоёулаа оролцож, УИХ-ын дарга нь

дэмжилцэж байсан нь энэ цувралд ашигласан баримтаар нотлогдож байгаа билээ.

- Ерөнхийлөгч, ерөнхий сайдаар толгойлуулсан “ураны бүлэглэл” ам бүл нэмж, өнөр өтгөн болжээ. Шамдан ажиллагсдыг дотор нь хэлэлцэн тохирогчид, гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурагчид, ил хэрэгжүүлэгч хэсгийнхэн, далдаас дэмжигчид, ухуулга сурталчилгаа буюу “пиар”-ын багийнхан гэх мэтээр хэд хэд ангилж болмоор болсон аж.

Тэдний зарим нэгний талаар өгүүлвэл:

УИХ-ын дарга Д. Дэмбэрэл. Энэ хүн гол рольд тоглодоггүй ч ерөнхийлөгч, ерөнхий сайд хоёртоо тус болохоор хичээсэн “мөрөөрөө” нэгэн. Тухайлбал, 2009 оны 7 сарын 16-нд цоорхойтой Цөмийн Энергийн хуулийг шахсаар байж батлуулсан хүний нэг нь Д. Дэмбэрэл. “С. Баяр дарга захисан”, “ҮАБЗ-өөс шуурхай батла гэсэн удирдамж ирсэн” гэсээр байж тэрбээр УИХ-ын гишүүдээр батлуулж чадсан.



Тэрбээр 2010 оны 4 сард Францын Элчин сайд Жан Поль Дюмоныг хүлээн авч Монгол улс ураны нөөц, цөмийн энергийг ашиглахтай холбогдсон эрх зүйн үндсийг боловсруулахад Францын парламентын зүгээс анхаарал тавьж дэмжлэг туслалцаа үзүүлсэнд талархал илэрхийлсэн байна (104). Монголд уран олборлогчид дунд тэргүүлж яваа туршилтын олборлолтоо хийгээд эхэлсэн “Арева” групп нь Францын цөмийн салбарыг эзэгнэгч, Францын төр засагт өндөр нөлөөтэй.

Үүнээс үзвэл цөмийн энергийн бодлого, хуулийг хэний эрх ашигт нийцүүлэн зохиосон бэ гэдэг сонин юм.

2010 оны 10 сард Францын Гадаад Худалдааны сайд Анн-Мари Идрак айлчлахад Д. Дэмбэрэл мөн л хүлээн авч хоёр орны хооронд цөмийн эрчим хүч, ураны салбарт хамтран ажиллах боломж тавигдсаныг онцлон тэмдэглэж байв (105).

2010 оны 12 сард Д. Дэмбэрэл УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан, Ч. Сайханбилэг, Д. Одбаяр, Р. Гончигдорж, С. Оюун, Д. Тэрбишдагва нарын хамтаар Энэтхэг улсад айлчилж, улс төр, эдийн засаг төдийгүй цөмийн эрчим хүч, ашигт малтмалын талаар яриа хэлэлцээр өрнүүлж (106), Энэтхэгийн Цөмийн Энергийн Комиссын дарга Срикумар Баниржийтэй уулзаж ярилцжээ (107).



С. Энхбат vs. А. Ундраа

Цөмийн Энергийн газрын дарга “цөмийн хаягдал Монголд булшлах тухай албан бусаар ярьсан нь үнэн шүү дээ. Сүүлийн үед хэвлэлд гарч байгаа зүйлээс харахад гол эздээс нь энэ асуудлыг холдуулж над руу чиглүүлж байгаа нь анзаарагдаж байна. Хэн, хэнтэй юу ярьсныг хуралдаан тарсны дараа ярья” гэсэн ч гэнэтхэн бие нь муудаж, эмнэлэгт хүргэгдсэнээр нууцыг задалж амжсангүй (97).

С. Энхбат олон ч гэрээнд гарын үсэг зурсан ч дарга нарыгаа дагаж явж зурдаг байсан, шийдвэр гаргах түвшний хүн биш билээ. Түүнийг Цөмийн Энергийн газрын даргаар С. Баяр томилсон бөгөөд харин С. Батболдтой төдийлэн таарамжтай биш бололтой (108). Ямартаа л 2011 оны 2 сард “С. Энхбат ажлаасаа хусагдах нь” гэсэн яриа гарсан ч тэгэсгээд намжсан.

Харин тэр үед ГХ-ны тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд А. Ундраа “Би биш бол манай нөхрийг Цөмийн Энергийн газрын дарга болгочих” гэж гуйж явсан гэсэн мэдээ тарж байсан билээ (109). Тэгвэл саяхнаас С. Энхбатын суудал ганхаж, А. Ундраа дахиад л даргын суудал руу “авирч” эхэлсэн тухай мэдээлэл цацагдаж эхэллээ (110).

2011 оны 5 сарын “Дуусдаггүй яриа-- Цөмийн хаягдал” нэвтрүүлгээр УИХ-ын гишүүн Н. Батбаяр “ Ийм хор хөнөөлтэй юм бол Монгол улс уранаар оролдох хэрэггүй” гэхэд А. Ундраа



учиргүй сандарч “Тэгээд Арева, Мицубиши хоёр яах болж байнаа?” гэж байж билээ (82). Хүнийрхүү сэтгэлтэй тусгай элчин сайд Цөмийн Энергийн газрын даргаар томилогдвол “Монголд хүссэн ч хүсээгүй ч цөмийн хаягдал булна” гэсэн үг нь биелэх нь тодорхой. “Арчаагүй учраас Монголчууд харийн цөмийн хаягдал булуулсан” гэж сүүлд нь ярих буй заа.

“Тархи угаах” хэсгийнхэн буюу “Пиар”-чид:

УИХ-ын гишүүн О. Чулуунбат уг нь ураны асуудалд огт холбоогүй нэгэн баймаар. Гэвч түүнийг “Н.Энхбаярын даалгавраар Тайваны хогийг Монголд авчирч булсан” гэж ярьж бичсээр ирсэн. Докторын зэрэгтэй энэ эрхэм эрүүл саруул хүний толгойд багтамгүй зүйлүүд олон ярьсны дотор “цөмийн хаягдал хор хөнөөлгүй” гэх ярилцлага байдаг (83).



Мөн түүнчлэн 2011 оны 5 сарын 19-нд ТВ 25-аар цацагдсан “Цөмийн хаягдал--дуусдаггүй яриа” нэвтрүүлгийн үеэр О. Чулуунбат ноцтой мэдэгдэл хийсэн. Нэвтрүүлгийн 24 дэх минут орчимд тэрбээр “Вашигтоны стратеги центрийн нэг хүн зун ирэхээр нь би уулзсан. Тэр хүн Монгол улс ийм их урантай юм чинь түлш боловсруулдаг төв байгуулвал. Монгол улс дэлхийн хамгийн том хэрэглэгчдийн дунд юм байна...Танайх уранаа эндээ боловсруулаад, түлш гаргаад, гадны орнуудад гаргаад, буцаагаад тэр түлшээ буцааж авдаг юм байна ш дээ. Ер нь бол олон улсын стандарт бол тэр түлшээ буцааж авч байх ёстой. Танайх буцааж аваад дахиж боловсруулаад ахиад сайн чанарын түлш болгож гаргадаг ийм л технологи байдаг. Энэнээсээ гарсан янз бүрийн цацрагийн хог байна даа, тэрнийгээ харин та нар өөрсдөө эндээ булж байх ёстой. Энэ асуудал бол яригдаж байсан. Би тэрийг сайн санаж байна. Энэ бол Монголчуудад нэг их хортой эд биш” гэж ярьсан. Чухамхүү ураны салбарт огт хамаагүй энэ эрхэм ямар хүнтэй хэзээ уулзаж ингэж ярилцсан бэ гэдэг учир битүүлэг үлдэв.



Академич Б. Чадраа. Цагтаа Монголын ШУА-ийг тэргүүлж явсан тэтгэврийн насны энэ хүн сүүлийн үед уран олборлох, АЦС байгуулах, цөмийн хаягдал булшлах талаар сонин хэвлэлээр олон удаагийн ярилцага өгч, цэнхэр дэлгэцээр гарах болсон нь цаанаасаа нарийн зохион байгуулалттай “пиар” маягтай. Тэрбээр ярилцлага бүртээ АЦС-ын ач холбогдлыг магтаж, нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан

станцаас хор багатай гэж ухуулдаг бөгөөд цөмийн хаягдлыг булшлах боломжтой, манай говь хамгийн тохиромжтой гэх мэт шинжлэх ухааны үндэслэлгүй, оргүй хоосон зүйл сурталчилдаг (85) Доорх зураг бол Өмнөд Солонгосчуудтай цөмийн салбарт хамтрах гэрээ байгуулчихаад, хөл нь газар хүрэхгүй баярлаж байсан 2009 оны 4 сарын 28-ны өдрийн дурсамж билээ (111).



УИХ-ын гишүүн П. Алтангэрэл. Дорнод аймгаас сонгогдсон энэ гишүүн



эхлээд ураны болон цөмийн энергийн асуудалд нилээдгүй шүүмжлэлтэй хандаж, хуулийн цоорхойнуудыг зааж шүүмжилж байсан удаатай. Нэн ялангуяа Цөмийн Энергийн тухай хуулийн хяналт сул байгааг тэмдэглэж, 2009 оны намраас хуулинд өөрчлөлт хийх санал оруулна хэмээн зарлаж байсан удаатай. Гэвч нөгөө “эхлээд хууртагдаж явсан ч дундаас нь хуурах ажилд оролцсон” гэгчээр зун 7 сард хуулийг эсэргүүцэж байсан гишүүн маань

хэдхэн сарын дараа түүнтэйгээ эвлэрч, улмаар “улаан фэн” нь болоод Р. Бадамдамдинг дагаж АНУ, Канадаар айлчилж, туршлага судлаад, “цөмийн түлшний банк” байгуулахыг тууштай дэмжигч болж хувирсан билээ (45, 46).

ҮРГЭЛЖЛЭЛ БИЙ

Ашигласан эх сурвалжууд:

- (1) Э. Амарлин. Цуврал 1: Цөмийн хаягдлын бизнест хэн хэн оролцож байна вэ?? 2011 оны 9 сарын 5. <http://golomt.org/2011/09/06/who/>
- (2) Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Дмитрий Анатольевич Медведев нар улс хоорондын стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглалд гарын үсэг зурлаа. Ерөнхийлөгч Ц. Элбэгдожийн цахим сайт, Ерөнхийлөгчийн Тамгын Газар. 2009 оны 8 сарын 25. <http://www.president.mn/mongolian/node/154>
- (3) Bruce Pannier. Russian President Signs China-Style Energy Deals With Mongolia. Radio Free Europe/ Radio Liberty мэдээллийн сайт, 2009 оны 8 сарын 25. http://www.rferl.org/content/Russian_President_Signs_ChinaStyle_Energy_Deals_With_Mongolia/1807283.html
- (4) Бибудата Прадхан. India, Mongolia Sign Civil Nuclear Agreement for Uranium Supply. Блумберг олон улсын санхүүгийн мэдээллийн сайт, 2009 оны 9 сарын 14. <http://www.bloomberg.com/apps/news?pid=newsarchive&sid=agwXtwrJJHk8>
- (5) К. В. Прасад. India, Mongolia ink pact for uranium supply. The Hindu сонин, 2009 оны 9 сарын 14. <http://www.thehindu.com/news/national/article20242.ece>
- (6) India, Mongolia ink uranium supply pact, four other agreements. Thaindian News сонин, 2009 оны 9 сарын 14. http://www.thaindian.com/newsportal/india-news/india-mongolia-ink-uranium-supply-pact-four-other-agreements_100247300.html
- (7) India, Mongolia Sign for "Peaceful use of Radioactive Minerals & Nuclear Energy". United Press International, 2009 оны 9 сарын 15. <http://www.ecoworld.com/energy-fuels/india-mongolia-radioactive-minerals-nuclear.html>
- (8) Ц.Элбэгдорж: Ураны салбарт хамтран ажиллах сонирхлыг бид дэмжих болно. Ерөнхийлөгч Ц. Элбэгдожийн цахим сайт, Ерөнхийлөгчийн Тамгын Газар. 2009 оны 9 сарын 15. <http://www.president.mn/mongolian/node/190>
- (9) Indian nuclear experts team to visit Mongolia for modalities. DNA India сонин, 2009 оны 1 сарын 11. http://www.dnaindia.com/india/report_indian-nuclear-experts-team-to-visit-mongolia-for-modalities_1333482
- (10) India to undertake uranium mining in Mongolia. New Delhi, 2011 оны 1 сарын 13. The Hindu сонин. <http://www.thehindu.com/news/international/article80341.ece>
- (11) R. Vasudevan. Mongolia offers big scope for mining, Indian president Patil says. The Asian Tribune, өдөр тутмын мэдээний цахим сонин. 2011 оны 7 сарын 31.

<http://www.asiantribune.com/news/2011/07/30/mongolia-offers-big-scope-mining-indian-president-patil-says>

(12) Areva signs Mongolian memorandum. Олон Улсын Цөмийн Энергийн Нийгэмлэгээс (World Nuclear Association) эрхлэн гаргадар World Nuclear News цахим сэтгүүл. 2009 оны 10 сарын 7. <http://www.world-nuclear-news.org/newsarticle.aspx?id=26268&terms=Mongolia>

(13) БНФУ-ын “Арева” групптэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Цөмийн Энергийн газрын цахим хуудас. http://nea.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=90:2009-10-05-10-15-09&catid=40:2009-09-30-06-42-31&Itemid=29

(14) С.Батболд: Цөмийн технологи хөгжлийн боломжийг нээж байна.Иргэний нийгмийн ТАН эвслийн цахим сайт. 2009 оны 12 сарын 21. <http://www.eiti.mn/old/mon/content/view/409/43/>

(15) Ерөнхий сайд С.Батболдын Австри, Унгар улсад хийсэн айлчлалын үр дүнгийн талаарх мэдээлэл. 2010 оны 3 сарын 19. <http://vip76.mn/zasqiin-gazryn-medee/10761-eronxii-said-sbatboldyn-avstri-ungar-ulsad-xiisen-ailchlalyn-ur-dungiin-talaarx-medeelel.html>

(16) Chinese premier vows closer ties with Mongolia. Бүгд Найрамдах Хятад Улсын Засгийн Газрын сайт. Эх сурвалж: Xinhua агентлаг. 2010 оны 4 сарын 13. http://www.gov.cn/english/2010-04/13/content_1580119.htm

(17) Hu Jintao Holds Talks with Mongolian President Elbegdorj. Бүгд Найрамдах Хятад Ард улсын Гадаад Хэргийн Яамны цахим сайт. 2010 оны 5 сарын 1. <http://www.mfa.gov.cn/eng/wjb/zzjg/yzs/gjlb/2742/2744/t689932.htm>

(18) Цөмийн энергийн салбарт хамтран ажиллана. Өнөөдөр сонин, 2010 оны 6 сарын 2. <http://www.mongolnews.mn/i/5636>

(19) Paul French. Mongolian-Chinese uranium deal could set prices soaring. Asia Correspondent мэдээллийн сайт. 2010 оны 6 сарын 13. <http://analysis.nuclearenergyinsider.com/industry-insight/mongolian-chinese-uranium-deal-could-set-prices-soaring>

(20) China and Mongolia signed the Memorandum of Understanding on Nuclear Power Cooperation. China National Nuclear Corporation цахим сайт. 2010 оны 7 сарын 19. <http://www.cnncc.com.cn/tabid/166/InfoID/48611/frtid/141/Default.aspx>

(21) 800 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл авах боломж нээгдлээ. “Өнөөдөр” сонин, 2011 оны 6 сарын 2. <http://www.mongolnews.mn/i/5676>

- (22) ГХ-ны сайд Г.Занданшатар: “Монгол, Казакстаны Засгийн газар хоорондын комисс ойрын үед хуралдана. Inet.mn мэдээллийн сайт. 2010 оны 6 сарын 13.
http://www.inet.mn/?vfile=5&vmet_id=22234&vmet_main=3327&vt=archive&vl=archive&vdate=&vofile=wytai5&left=yes&vpage=101
- (23) Okada Reiterates Interest in Mongolian Resources. PanOrient News мэдээллийн сайт. 2010 оны 8 сарын 30.
<http://www.panorientnews.com/en/news.php?k=352>
- (24) Meeting between Mr. Katsuya Okada, Minister for Foreign Affairs, and Mr. Dashdorj Zorigt, Minister for Mineral Resources and Energy of Mongolia. Япон улсын Гадаад Хэргийн Яамны сайт. 2010 оны 7 сарын 29.
http://www.mofa.go.jp/announce/announce/2010/7/0729_02.html
- (25) Minister of Mineral Resources Visits Japan. “The Mongol Messenger” сонин, 2010 оны 8 сарын 6. http://www.un-mongolia.mn/UNDP-in-the-News/Mongol_Messenger_06Aug.pdf
- (26) MOU with Mongolian Government for Operational Cooperation Promoting Japanese Firms’ Trade and Investment in Mongolia. The Japan Bank of International Cooperation цахим сайт. 2010 оны 8 сарын 3.
<http://www.ibic.go.jp/en/about/press/2010/0803-01/index.html>
- (27) Cooperation with Mongolia in Geological Survey and Mineral Resource Research. The National Institute of Advanced Industrial Science and Technology (AIST) цахим сайт. http://www.aist.go.jp/aist_e/aist_today/2011_39/in_brief.html
- (28) Б. Цэцэгсүрэн. АНУ манайхтай цөмийн эрчим хүчний салбарт хамтарна. “Өнөөдөр” сонин, 2010 оны 9 сарын 23. <http://www.mongolnews.mn/i/10683>
- (29) Д. Оюун. Монгол Улс АНУ-тай эрчим хүчний салбарт хамтарна. “Ардын эрх” сонин, 2010 оны 9 сарын 22 <http://politics.news.mn/content/30578.shtml>
- (30) Орчуулсан Д. Цэрэндолгор. Япон, АНУ Монголд цөмийн түлшний хаягдал агуулах байр барих талаар хэлэлцэж байна. “Өдрийн сонин”, 2011 оны 5 сарын 16.
http://www.dailynews.mn/?vfile=7&vmet_id=19112&vmet_main=6858
- (31) Шадар сайд М.Энхболд АНУ-ын Эрчим хүчний дэд сайдыг хүлээн авч уулзлаа. 2010 оны 9 сарын 22. <http://www.vip76.mn/component/content/article/3-uil-yavdlyn-medee/15713-shadar-said-menxbold-anu-yn-erchim-xuchnii-ded-saidyg-xuleen-avch-uulzlaa.html>
- (32) Moname Center cosponsored a public lecture of Deputy Secretary of Energy Daniel B. Poneman. “МонАме” эрдэм шинжилгээ, судалгааны төвийн цахим сайт.

http://www.monamescience.org/index.php?option=com_content&view=article&id=48%3Amoname-center-cosponsored-a-public-lecture-of-deputy-secretary-daniel-b-poneman&catid=1%3Anews&Itemid=9

(33) Францын Гадаад Худалдааны сайд Анн-Мари Идракийн айлчлалын тухай дараахь эх сурвалжуудаас үзнэ үү:

- Н. Түвшин. Цөмийн энергийн салбарт хамтран ажиллана. 2010 оны 10 сарын 14. <http://economy.news.mn/content/34244.shtml>

- Э. Болор. Францын Гадаад худалдааны сайд хатагтай Анн-Мари Идрак “Louis Vuitton”, “Occitane” компанийн дэлгүүрүүдэд очсоныхоо дараа Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид бараалхана. 2010 оны 10 сарын 13. <http://www.shuud.mn/index.php?option=news&task=view&id=9410&PHPSESSID=cb377ce6c1f1bb495594cbccfdad80d2>

(34) PM and Mongolian Prime Minister Sükhbaatar Batbold strengthen Canada-Mongolia relations. Канад улсын ерөнхий сайд Стивен Харперын албан ёсны цахим сайт. 2010 оны 9 сарын 28. <http://pm.gc.ca/eng/media.asp?id=3675>

(35) У. Оргилмаа. “Арева”-гийн Монгол дахь салбарын захирлыг өөрчилнө. 2010 оны 10 сарын 18. <http://mobile.news.mn/mcontent/34753.shtml?s=biznesq>

(36) Д. Саруул. Асашёорюү зодог тайллаа. “Өдрийн Сонин”. http://www.dailynews.mn/?vfile=8&vmet_id=14919&vmet_main=740

(37) Japan Looks to Mongolia for Rare Earths. PanOrient News мэдээллийн сайт. 2010 оны 10 сарын 3. <http://www.panorientnews.com/en/news.php?k=473>

(38) Yusuke Miyazawa. Japan to Increase Rare-Earth Imports From Mongolia, Asahi Says. Bloomberg Businessweek сэтгүүл, 2010 оны 10 сарын 3. <http://www.businessweek.com/news/2010-10-03/japan-to-increase-rare-earth-imports-from-mongolia-asahi-says.html>

(39) Japan, Mongolia OK Joint Rare Earths Development. 2010 оны 10 сарын 2. Цахим блог. <http://www.raremetalblog.com/2010/10/japan-mongolia-ok-joint-rare-earths-development.html>

(40) Монгол улсын Ерөнхий сайд С.Батболд Японы Ерөнхий сайдтай уулзлаа. 2010 оны 10 сарын Х. <http://www.open-government.mn/read-130-Япон.html>

(41) Japan-Mongolia Summit Meeting. Япон улсын Гадаад Хэргийн Яамны сайт. 2010 оны 11 сарын 19. http://www.mofa.go.jp/announce/announce/2010/11/1119_03.html

- (42) Rare Earth is Hot Topic in Japan-Mongolia Summit. PanOrient News мэдээллийн сайт. 2010 оны 11 сарын 19.
<http://www.panorientnews.com/en/news.php?k=550>
- (43) Монгол, Японы хамтарсан мэдэгдэл. Ерөнхийлөгч Ц. Элбэгдоржийн цахим сайт. 2010 оны 11 сарын 22. <http://www.president.mn/mongolian/node/1335>
- (44) Toshiba Signs Memorandum of Understanding on Cooperation in Development of Mineral Resources and Social Infrastructure with Mongolia's MNFCC. Тошиба корпорацийн сайт. 2010 оны 11 сарын 26.
http://www.toshiba.co.jp/about/press/2010_11/pr2601.htm
- (45) УИХ-ын гишүүн П.Алтангэрэл, Ц.Батбаяр нар Вашингтонд очиж Цөмийн эрчим хүчний салбарын туршлагаас судлажээ (Архивын мэдээ). 2010 оны 11 сарын 12. http://tsag.mn/index.php?option=com_content&view=article&id=3954:2011-05-10-05-11-21&catid=71:uih&Itemid=415
- (46) П.Алтангэрэл: Шар нунтагаа олборлоно, баяжуулна, цөмийн түлш болгоно гэхэд шоолоод байсан. 2010 оны 11 сарын 19.
<http://www.vip76.mn/altangerelpg/onclick-medee/18462-uix-yn-qishuun-paltangerel-cbatbayar-nar-vashingtong-ochij-comiin-erchim-xuchnii-salbaryn-turshlagaas-sudlajee-.html>
- (47) 3. Гил. Атомын энергийн асуудлаар ярилцав. 2010 оны 11 сарын 1.
<http://economy.news.mn/content/37274.shtml>
- (48) ОУАЭА-ийн ерөнхий захирал айлчилж байна. Монгол улсын Гадаад Харилцааны Яамны сайт. 2010 оны 11 сарын 1.
http://www.mfat.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=563%3A2010-11-01-02-38-18&Itemid=63&lang=mn
- (49) Олон улсын атомын энергийн агентлагт ажлын айлчлал хийв. Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албаны мэдээ, 2008 оны 4 сарын 17.
<http://news.gogo.mn/r/24401>
- (50) Developing multinational radioactive waste repositories: Infrastrutural framework and scenarios of cooperation. IAEA-TECDOC-1413. Олон Улсын Атомын Энергийн Агентлаг, 2004 оны 10 сар. http://www-pub.iaea.org/MTCD/publications/PDF/te_1413_web.pdf
- (51) Орчуулсан Э. Амарлин. Гэрээний төсөлд Монгол Улсад цөмийн хаягдал түлш байршуулна гэж заажээ/Draft accord notes Mongolia as home for spent nuclear fuel. Mainichi Shimbun сонин, 2011 оны 7 сарын 19.
<http://golomt.org/2011/07/20/0720/#more-1991>

- (52) Засгийн газрын тэргүүн нарын хэлэлцээний дүнгийн тухай хамтарсан албаны мэдээ. Монгол улсын Гадаад Харилцааны Яам. Олон нийттэй харилцах газар. 2010 оны 12 сарын 6.
http://www.mfat.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=623%3A2010-12-16-08-07-06&Itemid=63&lang=mn
- (53) Госкорпорация "Росатом" и Агентство по атомной энергии Монголии согласовали порядок и условия создания совместной уранодобывающей компании "Дорнод уран". Российское Атомное Сообщество. 2010 оны 12 сарын 14.
<http://www.atomic-energy.ru/news/2010/12/14/16764>
- (54) Россия списала долг Монголии. "Российская Газета" сонины материал, "Новая Политика" цахим сэтгүүл. 2010 оны 12 сарын 15. <http://www.novopol.ru/-rossiya-spisala-dolg-mongolii-text93834.html>
- (55) Emerging Nuclear Energy Countries. World Nuclear Association. Шинэчилсэн 2011 оны 9 сар. <http://www.world-nuclear.org/info/inf102.html>
- (56) Ерөнхий сайд С. Батболдын Кувейт улсад хийсэн албан ёсны айлчлалын дүнгээр гаргасан хэвлэлийн хамтарсан мэдэгдэл. 2011 оны 1 сарын 6.
<http://www.open-government.mn/read-279-Кувейт.html>
- (57) Арабын Нэгдсэн Эмират Улсад цөмийн түлш нийлүүлнэ. "Өнөөдөр" сонин, 2011 оны 1 сарын 11. <http://www.mongolnews.mn/i/14978>
- (58) Монгол улсын Ерөнхий сайд С.Батболдын Булангийн орнуудад хийсэн айлчлал амжилттай, бас ажил хэрэгч болж өнгөрлөө. <http://www.open-government.mn/read-400-Кувейт.html>
- (59) Б. Долзодмаа. Цөмийн хаягдлыг Монголын нутагт агуулбал мөнгө өгнө гэж хэмжээг нь хүртэл хэлээд байна. "Өдрийн сонин", 2011 оны 5 сарын 16.
<http://www.dailynews.mn/publish/?vid=19095>
- (60) Б. Долзодмаа. Ерөнхий сайд С.Батболд цөмийн хаягдлаа буцааж авах талаар Арабынхантай ярьжээ. "Өдрийн Сонин", 2011 оны 5 сарын 18.
http://www.dailynews.mn/?vfile=7&vmet_id=19174&vmet_main=6887
- (61) Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд хийсэн мэдээлэл. "Өнөөдөр" сонин, 2011 оны 1 сарын 21.
<http://www.mongolnews.mn/i/15436>
- (62) Sujin Thomas. Singapore may get nuclear power plant. AsiaOne Сингапурын мэдээллийн портал. 2010 оны 11 сарын 2.

<http://www.asiaone.com/News/AsiaOne+News/Singapore/Story/A1Story20101102-245235.html>

(63) Австрали Монголын хамтарсан мэдэгдэл. Австралийн ерөнхий сайд Жулия Гиллиардын цахим сайт. 2011 оны 2 сарын 23. <http://www.pm.gov.au/press-office/australia-mongolia-joint-statement>

(64) Delegation of UAE in Mongolia. Эх сурвалж: МОНЦАМЭ. М.А.Д. компанийн цахим сайт. <http://www.mad-mongolia.com/news/mongolia-news/delegation-of-uae-in-mongolia-4208/>

(65) Deputy PM meets with UAE delegation. Австрийн Вена хот дахь Монголын ЭСЯ-ны сайт. 2011 оны 2 сарын 18. http://www.embassymon.at/news/news_312.html

(66) Хятадын Гадаад хэргийн сайд Монголд ирлээ. 2011 оны 2 сарын 24. <http://politics.news.mn/content/55638.shtml>

(67) Mongolian Prime Minister Meets with Yang Jiechi . Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гадаад Хэргийн Яамны сайт. 2011 оны 2 сарын 25. <http://www.fmprc.gov.cn/eng/zxxx/t802976.htm>

(68) Prime ministers of S. Korea, Mongolia to hold talks. YONHAP News агентлаг. 2011 оны 3 сарын 21. <http://english.yonhapnews.co.kr/national/2011/03/21/21/0301000000AEN20110321001700315F.HTML>

(69) Mongolia and Korea to collaborate in Nuclear Energy. М.А.Д. компанийн цахим сайт. Эх сурвалж: МОНЦАМЭ. <http://www.mad-mongolia.com/news/mongolia-news/mongolia-and-korea-to-collaborate-in-nuclear-energy-4912/>

(70) Korea-Mongolia MOU for nuclear energy cooperation. KONICOF (Korea Nuclear International Cooperation Foundation) цахим сайт. http://eng.konicof.or.kr/04_news/01_international.php?req_P=bv&req_BIDX=1&req_BN M=c2c95a250c7cbd2fb54500f02ca80e26&req_VI=295&req_PC=0&req_CG=&sCATE=&sCHAR=

(71) АНУ-ын хамтын ажиллагаа: Хэзээ ба хэнтэй? салбар хуралдааны протокол. 2011 оны Карнегийн Сангийн Цөмийн Бодлогын Бага Хурал. АНУ, Вашингтон, ДС. 2011 оны 3 сарын 29 / 2011 Carnegie Nuclear Policy Conference. U.S. Nuclear Cooperation: How and With Whom? Transcript.

00:17:00 минут болон 00:52:43 минутаас эхлэнэ.

- Хурлын протокол: http://carnegieendowment.org/files/US_Nuclear_Cooperation-How_and_With_Whom.pdf

- Аудио бичлэг: <http://newmediamanager2.net/popup/1518>
- (72) Гадаад Харилцааны сайд Г. Занданшатар АНЭУ-д ажлын айлчлал хийв. Монгол улсын Гадаад Харилцааны Яамны сайт. 2011 оны 4 сарын 11.
http://www.mfat.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=751%3A2011-04-08-10-04-25&catid=43%3A2009-12-20-21-55-03&Itemid=62&lang=mn
- (73) Гадаад Харилцааны сайд Япон улсын Элчин сайдыг хүлээн авч уулзав. Монгол улсын Гадаад Харилцааны Яамны сайт. 2011 оны 5 сарын 10.
http://www.mfat.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=829%3A2011-05-10-07-51-18&catid=43%3A2009-12-20-21-55-03&Itemid=62&lang=mn
- (74) Ж. Гангаа. Монголчуудын гуравдагч хөрш АМЕРИК ОРНООР. “Өдрийн сонин”, 2011 оны сарын 22.
<http://www.dailynews.mn/publish/?vid=19839&vt=item&user=9m27esz8i11&vpage2=>
- (75) Л. Мөнхтөр. Миний асуулт ба ерөнхийлөгчийн хариулт. 2011 оны 6 сарын 29.
<http://www.orloo.info/readfull/politics/7369-asuult>
- (76) Монгол Улс, Америкын Нэгдсэн Улсын хамтарсан мэдэгдэл. Ерөнхийлөгч Ц. Элбэгдоржийн цахим сайт. 2011 оны 6 сарын 20.
<http://www.president.mn/mongolian/node/1891>
- (77) Стэнфордын их сургуулийн цахим сайт.
http://fsi.stanford.edu/publications/fueling_the_future_mongolian_uranium_and_nuclear_power_plant_growth_in_china_and_india
- (78) Thomas Cochran болон бусад. Fast Breeder Reactor Programs: History and Status. Судалгааны тайлан. 2010 оны 2 сар.
http://www.fissilematerials.org/ipfm/site_down/rr08.pdf
- (79) Olkiluoto Nuclear Power Plant. Википедиа, интернэтийн үнэгүй лавлагаа.
http://en.wikipedia.org/wiki/Olkiluoto_Nuclear_Power_Plant
- (80) Into Eternity (“Харанхуйн зүг өнгийвөөс”). Зургийн дарга М. Мадсен. Финляндын Онкало цөмийн хаягдлын нуувчны тухай баримтат кино, МҮОНТВ-ээр 2011 оны 9 сарын 17-нд цацагдсан.
- (81) Paul Webster. Should the U.S. More Tightly Control Nuclear Fuel It Makes? 2011 оны 3 сарын 29. <http://news.sciencemag.org/scienceinsider/2011/03/should-the-us-more-tightly-control.html>
- (82) Дуусдаггүй яриа–цөмийн хаягдал. Шууд нэвтрүүлэг. ТВ25. 2009 оны 5 сарын 21. Цөмийн хаягдал баялаг болох тухай А. Ундраагийн яриа.
<http://www.youtube.com/watch?v=YPT5SJgXihw&feature=related>

- (83) Б. Билгүүн. П.Алтангэрэл: Яг үнэндээ Оюутолгой, Тавантолгойн дэргэд уран нь өндөр ач холбогдолтой. 2009 оны 7 сарын 20.
<http://www.vip76.mn/altangerelpg/xevleliin-toim/xevleld-ogson-yarilclaga/7064-paltangerel-yag-unendee-oyuutolgoi-tavantolgoin-derged-uran-ni-ondor-ach-xolbogdoltai-.html>
- (84) Го. Энхтөр. О.Чулуунбат: Улаанбаатарын утаа, ил жорлонгоос цөмийн хаягдал арав дахин бага хортой байдаг. “Өнөөдөр” сонин, 2011 оны 4 сарын 6.
<http://mongolnews.mn/i/17931>
- (85) С. Зоригт. Академич Б.Чадраа: Монголчууд ухаантай болохоор атомын цахилгаан станц барихгүй бусад нь тэнэг учраас бариад байгаа юм биш. 2011 оны 5 сарын 24. <http://mass.mn/d/3028>
- (86) World's Largest Robot for Swedish Final Nuclear Repository. 2011 оны 3 сарын 29. <http://robotland.blogspot.com/2011/03/worlds-largest-robot-for-swedish-final.html>
- (87) Сьюзан Лоренс. Mongolia: Issues for Congress. Конгрессийн Судалгааны Алба. 2011 оны 6 сарын 14. Англи эх: <http://www.fas.org/sgp/crs/row/R41867.pdf>
Монголоор хэсэгчлэн орчуулсан хэсэг: <http://golomt.org/2011/06/23/0623/>
- (88) Workshop on “Important Considerations for Introducing Nuclear Power in ASEAN: Can Regional Cooperation be Attractive for Nuclear Energy Development?” Summary. http://www.n.t.u-tokyo.ac.jp/gcoe/jpn/research/nonproliferation/docs/Summary_Todai-UKM_workshop_31May-1June2010.pdf
- (89) Монгол, Энэтхэгийн Ерөнхийлөгч нар айлчлалын талаар хэвлэл мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийв. Ерөнхийлөгч Ц. Элбэгдоржийн цахим сайт. 2011 оны 7 сарын 28. <http://www.president.mn/mongolian/node/1998>
- (90) Mongolia, India eye closer cooperation in nuclear energy, mining. 2011 оны 7 сарын 29. <http://balita.ph/2011/07/29/mongolia-india-eye-closer-cooperation-in-nuclear-energy-mining/>
- (91) India to push N-deals with South Korea, Mongolia. Headlines India. 2011 оны 7 сарын 22. <http://headlinesindia.mapsofindia.com/india-and-world/south-korea/india-to-push-n-deals-with-south-korea-mongolia-87351.html>
- (92) Chang Jae-soon. S. Korea, Mongolia agree to significantly boost resources, energy cooperation. YONHAP News агентлаг. 2011 оны 8 сарын 22.
<http://english.yonhapnews.co.kr/national/2011/08/22/57/0301000000AEN20110822008900315F.HTML>

- (93) Монгол улсын Ерөнхий сайд С.Батболд БНЭУ-ын Ерөнхийлөгчид бараалхлаа. <http://www.open-government.mn/read-1077-.html>
- (94) Америкт амардаг Ерөнхий сайд хэзээ ирэх вэ? “Өдрийн сонин”, 2011 оны 8 сарын 12. <http://www.dailynews.mn/publish/?vid=20690&user=7ubbn8bai195>
- (95) Америкт амарсан Ерөнхий сайд эх орондоо ирлээ. “Өдрийн сонин”, 2011 оны 8 сарын 18. http://www.dailynews.mn/?vfile=5&vmet_id=20822&vmet_main=3615
- (96) Б. Мандах. Цөмийн энергийн газрын даргад хариуцлага тооцно. “Ардын Эрх” сонин, 2011 оны 8 сарын 25. <http://politics.news.mn/content/78107.shtml>
- (97) С. Энхбат: Цөмийн хог хаягдлыг Монголд булшлах тухай албан бусаар ярьсан зүйл бий. “Өнөөдөр” сонин, 2011 оны 9 сарын 1. <http://www.mongolnews.mn/i/22668>
- (98) Ken Timmerman. US Promotes Nuclear Waste Dump in Mongolia. Newsmax.com, мэдээллийн сайт. 2011 оны 7 сарын 18. <http://www.newsmax.com/KenTimmerman/nuclearwaste-Mongolia-UAE-DanielPoneman/2011/07/18/id/403983>
- (99) Miles Pomper, Ferenc Dalnoki-Veress, Stephanie Lieggi, Lawrence Scheinman. Nuclear Power and Spent Fuel in East Asia: Balancing Energy, Politics and Nonproliferation. The Asia-Pacific сэтгүүл, 2010 оны 6 сарын 21. http://www.japanfocus.org/-ferenc-dalnoki_veress/3376
- (100) Э. Амарлин. Японы Гадаад Хэргийн дэд сайд үнэн гэж баталжээ буюу Майничи сонин “шар хэвлэл” мөн үү? Эх сурвалж: 2011 оны 5 сарын 12-ны Майничи сонин. 2011 оны 6 сарын 2. <http://golomt.org/2011/06/02/mainichi3/>
- (101) Б. Энх. Ураны төслийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна гэжээ. Эх сурвалж: Майничи сонин. 2011 оны 7 сарын 30. <http://world.news.mn/content/75778.shtml>
- (102) Ерөнхийлөгчийн туслахуудын ярилцлагууд:
- Цөмийн булшны талаар ямар ч яриа байхгүй. 2011 оны 8 сарын 23. Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх Л. Пүрэвсүрэнгийн ярилцлага. <http://politics.news.mn/content/77863.shtml>
 - Д.Баттулга: Ерөнхийлөгч цөмийн хаягдлыг эх орондоо булшлах талаар нэг ч яриа гаргахгүй. 2011 оны 8 сарын 25. Ерөнхийлөгчийн Тамгын Газрын дарга Д. Баттулгын ярилцлага. <http://www.mongolnews.mn/w/22459>

- Хаягдал булахыг хүсч байгаа хүмүүс бий. Ерөнхийлөгчийн үндэсний аюулгүй бодлогын зөвлөх М. Батчимэгийн ярилцлага. 2011 оны 8 сарын 30.
<http://politics.news.mn/content/78500.shtml>

(103) Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хоёр Цөмийн хаягдлын тухай зарлиг гаргажээ. 2011 оны 9 сарын 15. <http://shuud.mn/index.php?option=news&task=view&id=29542>

(104) Францын элчин сайдыг хүлээн авч уулзав. 2010 оны 6 сарын 14.
http://202.180.218.253/open-parliament/index.php?option=com_content&view=article&id=2657:2010-06-14-09-36-58&catid=56:2009-05-04-03-48-24&Itemid=205

(105) Монголчуудын сайн түнш байж чадахаа Францын сайд илэрхийлэв. 2010 оны 10 сарын 13. http://202.180.218.253/open-parliament/index.php?option=com_content&view=article&id=2948:2010-10-13-09-57-05&catid=56:2009-05-04-03-48-24&Itemid=205

(106) Demberel ends India visit after wide-ranging talks with leaders. 2010 оны 12 сарын 14. <http://english.news.mn/content/44850.shtml>

(107) Б. Хүдэр. D. Demberel meets speaker of Lok Sabha.
<http://www.mongoliaeconomy.com/?p=1356>

(108) Э. Болорхажид. Анхны үнэн үгийг унагасан С.Энхбат дарга та бүх үнэнийг дэлгэвэл яасан юм бэ? 2010 оны 9 сарын 6.
<http://www.shuud.mn/index.php?option=news&task=view&id=28827>

(109) Г. Отгонжаргал. Цөмийн энергийн салбар “хатан хаан”-тай болсон уу? 2011 оны 2 сарын 12. <http://mobile.news.mn/mcontent/53826.shtml?s=biznes>

(110) Л.Нинжсэмжид. Цөмийн энергийн газрын дарга С.Энхбатыг А.Ундраагаар солих гэнэ. <http://sonin.mn/?p=153272>

(111) 기후변화•에너지대책포럼, 몽골과 원자력 MOU 체결. 2009 оны 4 сарын 28.
http://www.dailian.co.kr/news/news_view.htm?id=155257